

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ,
ТЭДГЭЭРИЙГ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁОГ**

	Ирүүлсэн санал	Тусгасан байдал, тайлбар
I.Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо /Ашид билгүүн /		
1.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн “11 дүгээр зүйлийн 11.1.1. даатгагчаа чөлөөтэй сонгох” гэснийг “даатгагч болон даатгалын хохирол үнэлэгчийг чөлөөтэй сонгох” гэж, мөн 59 дүгээр зүйлийн “59.4. Энэ хуулийн 59.1.1-д заасан хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд тухайн даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг эрхэлж, даатгалын хохирлын үнэлгээг гаргана.” гэснийг “Даатгуулагчийн сонгосон хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдол болсон нөхцөлд тухайн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг эрхэлж, даатгалын хохирлын үнэлгээг гаргана” гэж тус тус өөрчлөх саналтай байна. Даатгалын харилцаа нь Иргэний эрх зүйн харилцаа бөгөөд Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн “1.2-т Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх ...зарчимд үндэслэнэ.” гэж заасан бөгөөд мөн хуулийн илүү нарийвчилсан зохицуулалт болон Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд заасан Даатгалын гэрээ нь “даатгагч, даатгуулах талуудын хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхийг хангасан гэрээний талуудын чөлөөт байдал” -ыг хангах ёстой. Гэтэл төсөлд Даатгалын тохиолдол болсон нөхцөлд даатгагчид давуу эрх олгож даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн хохирлын үнэлгээг нэн тэргүүнд хийхээр зохицуулж гэрээний чөлөөт байдлыг алдагдуулж байгаа нь даатгалын харилцааны мөн чанарт нийцэхгүй байгаа юм. Нөгөө талаар даатгуулагч нь “даатгалын хохирол үнэлэгчийг чөлөөтэй сонгож, даатгалын хохирлын үнэлгээг гаргуулах” нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн “11.1.1. үнэлгээчнийг сонгох” үйлчлүүлэгчийн эрхийг зөрчихгүй нийцнэ гэж үзэж байна.</p>	<p>Үгүй. Хуулийн төслийн 61.1-д даатгалын хохирол үнэлэгчийн харилцааг зохицуулсан бөгөөд даатгалын тохиолдлын үед нэн тэргүүнд даатгагчийн томилсон буюу даатгагчийн ажилтан нь хохирлын үнэлгээг хийх ба түүний дараа даатгуулагч хохирлын үнэлгээг зөвшөөрөхгүй бол төслийн 61.1.2-т заасан хөндлөнгийн хохирол үнэлэгч компанид хандах юм. Эндээс хөндлөнгийн хохирол үнэлэгч компанийг сонгох асуудал даатгуулагчид өөрт нь байгаа тул заавал ийнхүү тусгах шаардлагагүй гэж үзэж байна.</p>
2.	<p>Мөн төслийн 59 дүгээр зүйлийн “59.1.1.даатгагчийн томилсон хохирол үнэлэгч” гэснийг “даатгагчийн сонгосон хохирол үнэлэгч” гэж өөрчлөх саналтай байна. Эрх зүйн хувьд “томилох” гэдэг өөрийн байгууллагын ажилтныг тодорхой үүрэг гүйцэтгүүлэхээр ажил, албан тушаалд авч ажиллуулах тухай ойлголт бөгөөд харин хуулийн төсөлд тусгагдсан “даатгалын хохирол үнэлэгч” нь төслийн “59.2-т зааснаар Хорооноос эрх олгосон даатгалын хохирол үнэлэгчээр ажиллахад тохирох мэргэжил</p>	<p>Үгүй. Хуулийн төслийн 59.1-д даатгалын хохирол үнэлэгчийн харилцааг зохицуулсан бөгөөд даатгалын тохиолдлын үед нэн тэргүүнд даатгагчийн томилсон буюу даатгагчийн ажилтан нь хохирлын үнэлгээг хийх ба түүний дараа даатгуулагч хохирлын</p>

	<p>дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн” юм. Ийнхүү Хорооноос эрх олгогдсон даатгалын хохирол үнэлэгчээс сонгож даатгалын тохиолдол бүрд үнэлгээ хийлгэх байдлаар зохицуулах нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 4.1-т заасан Хөрөнгийн үнэлгээ хийхэд баримтлах “хараат бус байх, шударга байх, хууль тогтоомжид нийцсэн байх зарчим” болон “4.2.т заасан Хөрөнгийн үнэлгээ хийхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцохыг хориглоно” гэсэн хязгаарлалтад нийцэх юм. Өөрөөр хэлбэл даатгалын хохирол үнэлэгчийн эрх авсан иргэнийг сонгох, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн эрх бүхий хөндлөнгийн хохирол үнэлэгчтэй хамтарч ажиллах нөхцөлийг энэ хуулиар тогтоох шаардлагатай байна.</p>	<p>үнэлгээг зөвшөөрөхгүй бол төслийн 59.1.2-т заасан хөндлөнгийн хохирол үнэлэгч компанид хандах юм. Эндээс хөндлөнгийн хохирол үнэлэгч компанийг сонгох асуудал даатгуулагчид өөрт нь байгаа тул заавал ийнхүү тусгах шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>Ийм нөхцөл нь бүрэн нийцэж байгаа гэж үзэх үндэслэлтэй байна.</p>
3.	<p>Мөн нөгөө талаар хуулийн төслийн томъёоллыг үзвэл “даатгагчийн томилсон буюу санал болгосон этгээдэд” 59.2-т зааснаар Хороо эрх олгох байдлаар уншигдаж байгаа бөгөөд энэ нь “зөвхөн даатгалын мэргэшсэн хохирол үнэлэгч нь даатгалын хохирол үнэлэх эрхтэй байх” хөрөнгийн үнэлгээний мөн чанарт харшилж байна.</p>	<p>Үгүй. "зөвхөн даатгалын мэргэшсэн хохирол үнэлэгч нь даатгалын хохирол үнэлэх эрхтэй байх" гэсэн шаардлагын дагуу Хорооноос төслийн 59.1.1 болон 59.1.2-т заасан хохирол үнэлэгчид холбогдох шаардлагыг журмаар тогтоон, үйл ажиллагаагаа явуулах эрхийг олгох юм. Эрх олгосон хохирол үнэлэгч үйл ажиллагаагаа мэргэжлийн түвшинд хэрэгжүүлж буй эсэхэд Хорооноос тухай бүр хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллана.</p>
4.	<p>Хуулийн төслийн “59.2-т Хороо даатгалын хохирол үнэлэгчээр ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага ...” гэсэн шаардлагыг нэг бүрчлэн задалж энэхүү хуулийн төсөлд шинээр зүйл заалт болгон тусгах нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн “29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх” гэсэн хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагад нийцэх юм. Тодруулбал, хуулийн төслийн 14 дүгээр зүйлд заасан Хорооноос батлах Даатгалын журмын хүрээнд батлагдах журмаар биш энэхүү хуулиар тогтоох нь дээрх шаардлагад нийцэж байна. Иймд төслийн 59.2.1. Даатгалын хохирол үнэлэгчийн эрх авах иргэн нь дараах шаардлага хангасан байна. 59.2.1.1. Мэргэшсэн үнэлгээчин байх, 59.2.1.2. Хохирлын үнэлгээний чиглэлээр 1-ээс доошгүй жил ажилласан байх, 59.2.1.3. Хорооны болон Хохирол үнэлгээний мэргэжлийн байгууллагын хамтран зохион байгуулсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж сертификат авсан байх, 59.2.1.4. сүүлийн 2 жил даатгалын компанид ажиллаагүй байх. 59.3.1. Даатгалын хохирол үнэлэгчийн эрх авах хуулийн этгээд нь дараах шаардлага хангасан байна. 59.3.1.1. Хохирлын үнэлгээний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, 50 сая төгрөгөөс доошгүй өөрийн хөрөнгөтэй компани байх, 59.3.1.2. компани нь 5-аас доошгүй ажилтантай үүний 3 доошгүй нь мэргэшсэн үнэлгээчин байх,</p>	<p>Үгүй. Хуулиар ийм нарийвчилсан асуудлуудыг тусгах боломжгүй. Дэлхийн зах зээл, түүнд дотроо даатгалын зах зээл ч мөн хурдацтай хөгжиж буй энэ үед хэт нарийн зохицуулалтыг хуульд тусгаж өгснөөр шаардлагатай өөрчлөлтийг оруулах хэрэгцээ үүссэн үед хүндрэлтэй бөгөөд энэ нь салбарын хөгжлийг дэмжихгүй болох магадлалтай юм. Өөрөөр хэлбэл, шинэ төрлийн шаардлага тавих болгонд хуульд нэмэлт оруулах боломжгүй учраас, шаардлагын жагсаалтыг журмаар баталдаг байх нь зохимжтой. Журмаар зохицуулах үндэслэл нь хуульд туссан байх шаардлагатай учир энэ заалт байж болно.</p>

	<p>59.3.1.3. хохирол үнэлгээний мэргэжлийн байгууллагын гишүүн байх гэж зохицуулах шаардлагатай байна. Манай улстай ойролцоо даатгалын тогтолцоо бүхий улс болох Бүгд Найрамдах Солонгос улсад энэхүү харилцааг Даатгалын бизнесийн тухай хуулиар зохицуулж, Мэргэшсэн хохирол үнэлэгч болох этгээдэд “Санхүүгийн хяналтын үйлчилгээний албаны зохион байгуулах 2 түвшний шалгалтад тэнцсэн, ажлын 300 цагийн /6 сар/ дадлага хийсэн, эрдэм шинжилгээний 2-оос доошгүй нийтлэл бичсэн, даатгалд хамрагдсан г.м” гэсэн тавигдах шаардлага болон мөн мэргэшсэн хохирол үнэлэгчийн эрх олгож болохгүй этгээдийг тодорхойлж хуульчилсан байна. Харин эрх олгох процесс ажиллагаа болох шалгалтад оролцох этгээдийг бүртгэх, шалгалт авах, дадлага хийх хугацаатай холбоотой харилцааг журмаар зохицуулдаг байна. Хуулийн төсөлд гадаад улсын сайн туршлагыг тусгах хэрэгжүүлэх нь зохицуулалтыг боловсронгуй болгоход ач холбогдолтой.</p>	
5.	<p>Мөн төслийн “4 дүгээр зүйлийн 4.1.14 “даатгалын хохирол үнэлэгч” гэж даатгагч, даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдийг” гэснийг “даатгалын хохирол үнэлэгч” гэж даатгагч, даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө үйлчилгээний ажлын хөлс болон бусад төлбөр авах даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдийг” гэж өөрчлөх саналтай байна.</p>	Үгүй. Шаардлагагүй гэж үзэв.
II. Практикал даатгал		
1.	<p>Даатгалын хураамжийн тухай 8-р зүйлд заажээ. Хураамжийг тооцоолоход тавигдах шаардлагыг оруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд: даатгалын хураамж нь нөхөн төлбөр болон зардлыг санхүүжүүлэхэд хангалттай хүрэлцэхгүй байх, даатгалын хураамжийг үндэслэлгүйгээр өндрөөр тооцохгүй байх, ижил эрсдэл, нөхцөл бүхий 2 даатгалын зүйлд өөр өөр хураамж санал болгохгүй байх, бага зэргийн өөрчлөлт нь актуар тооцоололд үндэслэсэн байх.</p>	<p>Үгүй. Даатгалын хураамжийн хэмжээг даатгагч нь актуар тооцоололд үндэслэн өөрөө тооцох бөгөөд үүнийг хууль тогтоомжид тусгах шаардлагагүй бөгөөд тавигдах шаардлагыг журамд тусгах боломжтой.</p>
2.	<p>Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд даатгалын үндсэн зарчмууд тусгагдаагүй байдаг бөгөөд үүнээс үүдэн даатгуулагч болон даатгагчийн хооронд маргаан үүсэх, даатгалын үндсэн зарчим алдагдах тохиолдол гардаг тул даатгалын зарчмуудыг хуульд тусгах.</p>	<p>Үгүй. Төслийн 9.4, 9.5, 10.2, 11.1.2 дахь заалтуудад даатгалын нөхөн төлбөрийн зарчим, 9.7, 10.2.3, 11.2.3, 11.2.5, 14.2.13, 14.2.14, 69.1 дэх заалтуудад туйлын үнэнч шударга байх зарчим, 14.2.14-т контрибуци зарчим, 9.7.4, 9.10, 10.1.4 дэх заалтуудад суброгаци зарчим, 91, 92, 93 дугаар зүйлд</p>

		маргаан шийдвэрлэх зарчмыг тус тус тусгасан байна.
3.	Төслийн 4.1.13-д “актуарч” гэж ... үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдийг” гэдэг дээр нөөц, нөөц санг тооцоолох ... үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдийг; гэж нэмэх.	Үгүй. Даатгалын багц дүрэмд тусгах боломжтой.
4.	Төслийн 6.2.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөх саналтай байна. “Гэнэтийн осол, өвчний улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд тусгагдсан өвчнөөр нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах, эрүүл мэндэд хохирол учрах эрсдэлийн даатгал;”	Үгүй. Амьдралын даатгалд хамаарах тул хүлээж авах боломжгүй.
5.	Төслийн 6.2.2 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөх саналтай байна. Даатгуулагч гадаадад зорчих үед гэнэтийн ослоор эсвэл гадаадад зорчих үеийн даатгалын гэрээнд тусгагдсан өвчнөөр нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах, эрүүл мэндэд хохирол учрах эрсдэлийн даатгал;”	Үгүй. Амьдралын даатгалд хамаарах тул хүлээж авах боломжгүй.
6.	Хуулийн төслүүдээр даатгагч нар хэтэрхий олон төрлийн сан, холбоо байгуулахаар байна. Үүнд: Заавал даатгал хийх даатгагч нар нь хураамжийн тодорхой хувиар нийгэмд ээлтэй, ногоон бизнес үйл ажиллагааг дэмжих сан байгуулна. Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн 22.1-т Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нар Хохирогчийн эрхийг хамгаалах холбоо байгуулна. Хуулийн төслийн 32.1 Заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагч нар нь заавал даатгалын баталгаат сан байгуулна. Заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Заавал даатгалын холбооны гишүүн байна гэж тус тус заажээ. Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар Албан журмын даатгагчдын холбоо, хуулийн төсөлд Заавал даатгалын холбоо гэж нэрлэгдсэн энэ газраас нөхөн төлбөр олгох, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах талаар зохицуулалтыг тодорхой оруулаагүй, зөвхөн даатгагч нараас мөнгө хурааж авах талаар л зохицуулалт байх бөгөөд өнөөдрийг хүртэл хугацаанд энэ санд бүрдүүлж өгсөн мөнгө болон цаашид Даатгагч нараас авах мөнгийг хэрхэн зарцуулах нь ойлгомжгүй болжээ. Иймд даатгагч нараас олон төрлийн сан, холбоо байгуулж, гишүүнчлэлийн хураамж гэж татахын оронд АЖДХ-нд өнөөдрийг хүртэлх хуримтлагдсан мөнгийг олон нийтийн үйл ажиллагаанд зарцуулах, хохирогчийн эрх ашгийг хамгаалах зэрэгт зарцуулах, энэ талаар хуулийн зүйл заалт нэмэх саналтай байна.	Хэсэгчлэн тусгав. Заавал даатгал хийх даатгагч нар нь хураамжийн тодорхой хувиар нийгэмд ээлтэй, ногоон бизнес үйл ажиллагааг дэмжих сан байгуулах бус хураамжийн тодорхой хувийг нийгэмд ээлтэй, ногоон бизнес, үйл ажиллагааг дэмжихэд зориулан зарцуулахаар тусгасан. Мөн хуулийн төслийн "22.6.Хороо нь заавал даатгалын холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, зааврыг баталж, уг холбооны үйл ажиллагаанд хяналт тавина." гэж хуулийн төсөлд тусгасан байгаа бөгөөд Заавал даатгалын холбоон дээр байгуулах сангуудад Хороо хяналт тавих зохицуулалттай болно.
	Төслийн 32.5-д даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор хэд хэдэн даатгагч нар хамтран сайн дурын даатгалын баталгаат санг байгуулж болно гэж заажээ. Тус заалт нь олон улсын жишгийг дагаж даатгуулагчийг хамгаалах зохицуулалт хэдий ч сангийн хөрөнгийг даатгагч нар	Үгүй. "32.1.Даатгагч дампуурсан, түүний улмаас заавал даатгалын даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

7.	байгуулах нь зохимжгүй юм. Даатгалын салбарын 2022 оны 1 дүгээр улирлын тайлангаар ердийн даатгалын 1,9% гарсан ба үнийн өрсөлдөөн ихтэй салбар юм. Ийм нөхцөлтэй байгаа салбарт дахин хэд хэдэн сан байгуулах зохицуулалт гаргаж байгаа нь зохимжгүй гэж үзэж байгаа тул дээрх сангийн эх үүсвэрийг улсын төсвөөс гаргах эсвэл заавал даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг бүрдүүлэх саналтай байна.	бүхий даатгагч нар хамтран заавал даатгалын баталгаат санг байгуулна. " заалтын дагуу заавал даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч нар нь заавал даатгалын хураамжийн тодорхой хувиас уг санг байгуулах үүрэгтэй бөгөөд даатгагч дампуурсан тохиолдолд заавал даатгалд даатгуулсан даатгуулагч нарыг хохирох эрсдэлээс хамгаалах зорилготой. Харин төслийн 32.5-д заасны дагуу даатгагч нар нь сайн дурын даатгалд хамаарах баталгаат санг байгуулах эсэх нь нээлттэй. Баталгаат санг байгуулснаар даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, даатгуулагч нарын даатгалын салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой болно.
8.	Хуулийн төслийн 35.1 дэх заалтын хугацаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.3 дахь заалттай зөрчилдөж байх тул тайлан хүргүүлэх хугацааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд буюу 2 сарын 10-ны дотор хүргүүлэх гэдгээр заах саналтай байна.	Үгүй. Даатгал нь эрсдэлийг шилжүүлэн авч, ирээдүйд төлөх нөхөн төлбөрт зориулан даатгалын хураамж төвлөрүүлэн, түүгээрээ даатгалын нөөц сан бүрдүүлдэг онцгой зохицуулалт шаардсан санхүүгийн салбар. Тиймээс эрсдэлийг тухай бүр тооцоолох шаардлагатай бөгөөд энэ ч утгаараа хамгийн нарийн төвөгтэй тооцоолол болох даатгалын нөөц сангийн тооцооллыг өдөр бүр гаргах боломж даатгагчид бүрдсэн. Банкны тухай хуулийн дагуу банк санхүүгийн тайлангаа 1 дүгээр сард багтаан Монгол банканд ирүүлдэг. Даатгал бол банкнаас илүү өдөр бүр эрсдэлээ тооцоолох шаардлагатай төдийгүй программ хангамжийн хувьд хангалттай туршлагыг хуримтлуулсан тул даатгалын компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланг 1 дүгээр сард багтаан авах боломжтой юм.

9.	Хуулийн төслийн 49.2 дахь заалтад заасан хувь хэмжээгээр дотоодын давхар даатгагч эрсдэлийг дааж чадах эсэхийг СЗХ-д бүртгэлтэй давхар даатгалын гэрээнүүдийн мэдээллийг ашиглаж тооцоолол хийж шалгуулах саналтай байна.	<p>Үгүй. Даатгалын компаниуд 2019-2023 оны хооронд хураамжийн нийт орлогын 34.0 хувийг буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна.</p> <p>Олон улсын туршлагыг судалж үзэхэд: ОХУ-ын хуульд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг заавал даатгуулдаг. Беларусь улс - Belarus Re төрийн өмчит давхар даатгалын компанийг 2006 онд үүсгэн байгуулсан. 2006 онд 10 хувь, 2007 онд 20 хувийг шилжүүлдэг болгож, хуульд нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байгаа. Энэтхэгийн ердийн даатгалын компаниуд давхар даатгалынхаа 10 хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, 5 хувийг заавал шилжүүлэх зохицуулалттай байсан. Үүнээс үзэхэд ихэнх улсууд эхлээд давхар даатгалын зах зээлийг төрийн дэмжлэгтэйгээр өргөжүүлж, үүнийхээ дараа алхам алхмаар оролцоогоо бууруулах арга хэмжээг авдаг байна. Иймд нэг талаасаа дотоодын давхар даатгалын тогтолцоог сайжруулах, нөгөө талаас гадагшаа урсах мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах ач холбогдолтой.</p>
10.	Хуулийн төслийн 8 дугаар бүлэгт Актуарч болон актуар тооцоололтой холбоотой зохицуулалтуудыг заасан байх бөгөөд ямар тохиолдолд Актуарчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар зохицуулалт байхгүй тул энэ талаарх зохицуулалтыг нэмэх саналтай байна.	Үгүй. Актуарчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг Даатгалын багц дүрмээр зохицуулдаг, хуульд тусгах шаардлагагүй гэж үзэж байна.
11.	Хуулийн төслийн 59.3 дахь заалтыг хасах саналтай байна. Даатгалын тохиолдол болгон дээр Хороо мэдээ өгдөг байдал нь Даатгагчид хүндрэлтэй.	Үгүй. Даатгагч нь даатгалын тохиолдол болгон дээр хохирол үнэлэгчийг томилохгүй,

		<p>харин даатгагчийн томилсон хохирол үнэлэгч нь даатгагчийн ажилтан байна..</p> <p>Олон улсын практикт даатгалын хохирол үнэлэгчийг даатгагчийг төлөөлөх хохирол үнэлэгч буюу loss adjuster, даатгуулагчийг төлөөлөх хохирол үнэлэгч буюу public adjuster, мөн хараат бус хохирол үнэлэгч буюу independent loss adjuster гэж ангилдаг. Үүний дагуу хохирол үнэлэгчийг 2 ялган даатгалын компанийн ажилтан буюу даатгагчийн томилсон хохирол үнэлэгчээр эхэлж даатгалын хохирлын үнэлгээг хийж, даатгуулагч зөвшөөрвөл нөхөн төлбөрийг олгохоор зохицуулсан бөгөөд энэхүү үнэлгээг даатгуулагч зөвшөөрөхгүй бол хөндлөнгийн буюу хараат бус хохирол үнэлэгчээр үнэлгээг хийлгэнэ. Ингэснээр даатгалын хохирлын үнэлгээ хурдан шуурхай хийгдэх, даатгуулагчид даатгалын хохирлын үнэлгээний зардлын ачаалал буурах болон даатгалын салбарын нэр хүнд өсөх боломж бүрдэх юм. Мөн нөгөөтэйгүүр хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч илүү мэргэших боломж бүрдэнэ.</p>
12.	Хуулийн төслийн 77.1.3 дахь заалтын төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэсэн хэсгийг хасах саналтай.	<p>Үгүй. Ирүүлсэн саналын үндэслэл тодорхой биш, даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. /"Даатгалын тулгуур зарчим ICP 10. "Урьдчилан сэргийлэх болон засан залруулах арга хэмжээ"-т Зохицуулагч байгууллага нь даатгалын удирдлагын зорилтуудыг биелүүлэхийн тулд цагаа олсон, оновчтой урьдчилан сэргийлэх болон засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ." гэж заасан байдаг/</p>

III. “Үндэсний давхар даатгал” ХК

1	<p>49.2 Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар даатгалд шилжүүлэх даатгалын үнэлгээний 10-аас доошгүй хувийг энэ хуулийн 49.1.1-д заасан даатгагчид даатгуулна” гэжээ.</p> <p>1. Хөгжиж буй орнуудын хувьд давхар даатгалын баталгаат байдал болон эрсдэл тархаан байршуулах хэрэгцээ хоёрын зөв тэнцвэрийг олох нь чухал байдаг. Үндэсний давхар даатгалын тогтолцоо /National reinsurance system/-г хөгжүүлэх гол үндэслэл нь зөвхөн валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын хураамжийг улсдаа үлдээх бус дотоодын даатгалын зах зээлийг чадавхжуулчих, эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх, даатгалын мэргэжлийн үйл ажиллагааг төлөвшүүлэхэд оршдог. Үндэсний давхар даатгалын тогтолцоо гэдэг нь төрөөс баримталж буй санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд гадагш чиглэлтэй валютын урсгалыг багасгах, дотоодын даатгалын зах зээлийн чадавхыг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадамжийг өсгөх, даатгалын мэргэжлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх зорилгоор төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниар дамжуулан давхар даатгалын эрсдэл, хураамжийн тодорхой хувийг хуулийн дагуу дотооддоо авч үлдээж буй тогтолцоог ойлгодог.</p> <p>Хөгжиж буй орнуудын даатгалын компаниуд эрсдэл даах чадамж бага учраас орлогынхоо нэлээд хувийг гадаад руу давхар даатгалын хураамж хэлбэрээр шилжүүлэх гол үндэс болдог ба эргээд түүний багахан хувийг нөхөн төлбөр байдлаар авдаг. Даатгалын компаниуд 2014 оноос 2018 оны хооронд 213.3 тэрбум төгрөгийг давхар даатгалд зарцуулсан байх бөгөөд түүнээс 14,1 тэрбум төгрөгийг нөхөн төлбөрт авсан байдаг. Дээрх зардлын дийлэнх буюу 99 орчим хувийг гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн байна. Энэ байдал нь гадаад валютын нөөц болон худалдааны тэнцэлд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болдог. Аливаа улс орнууд гадаадын давхар даатгалд хэт тулгуурлавал даатгалын салбарынх нь эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө буурдаг гэж үздэг байна. Олон улсын туршлага /Жишээ нь: ОХУ, БНХАУ, БНСУ, БНЭУ, БНФУ, БНБУ, БНСВУ, КХУ/-д хөгжиж буй улс орнууд даатгалын салбараа хөгжүүлэхийн тулд засгийн газраас төрийн өмчит үндэсний давхар даатгалын компани байгуулж, гадаадын давхар даатгагчид шилжүүлж буй эрсдэл, хураамжийн 10-70 хувийг заавал дотоодын давхар даатгагчид шилжүүлэхийг хуулиар зохицуулж өгсөн байдаг. Мөн компанийн хөгжлийн явцад нь нээлттэй хувьцаат компани болгож, тодорхой хувийг нь хувийн хэвшилд шилжүүлэх, заавал давхар даатгуулах хувь хэмжээг нь нэмэгдүүлэх байдлаар салбарын хөгжлийг дэмжиж өгдөг байна. Үндэсний давхар даатгалын тогтолцоог бий болгосноор даатгалын зах зээл дээрх үнийн өрсөлдөөнийг хязгаарлах, ДОШ буюу даатгалын орлогын шимтгэлээр өрсөлдсөн далд эдийн засгийн тогтолцоог үгүй болгох, даатгалын зах зээлд мэргэжлийн үйл</p>	<p>Үгүй. Ярилцах шаардлагатай: Шийдэл: Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19.1-д Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгө, амь нас, эрүүл мэнд, хариуцлага, ашиг сонирхлыг гагцхүү тусгай зөвшөөрөл авахаар тусгасан байгаа тул дотоодын даатгалын компаниудын авах эрсдэлийн хэмжээ энэ хэмжээгээр өсөх, үүнийг дагаад дотоодын давхар даатгагчийн авах эрсдэлийн хэмжээ мөн өсөх юм.</p> <p>Олон улсын туршлагыг судалж үзэхэд: ОХУ-ын хуульд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг дотоодын давхар даатгагчид заавал даатгуулдаг.</p> <p>Беларусь улс- Belarus Re төрийн өмчит давхар даатгалын компанийг 2006 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2006 онд 10 хувь, 2007 онд 20 хувийг шилжүүлдэг болгож, хуульд нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байгаа. Хуульд зааж өгсний үр дүнд бүх давхар даатгалын гэрээ тус байгууллагаар дамждаг болж хяналт хийгдсэний дагуу Үндэсний давхар даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгож чадсан байна.</p> <p>Мөн түүнчлэн "дотоодын давхар даатгагч" гэж тусгаснаар МУ-ын даатгалын салбар дахь гаднын хөрөнгө оруулалт нэмэгдэх, дотоодын давхар даатгалын компани шинээр байгуулагдах, салбар тэлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.</p>
---	---	--

ажиллагааг төлөвшүүлэх үндсэн суурь нөхцөл болно. Үндэсний давхар даатгал нь мэргэжлийн актуар тооцоололд суурилсан даатгалын хураамжийн хувь гаргаж өгснөөр үнийн өрсөлдөөнийг хязгаарлаад зогсохгүй ДОШ-ийг мэдээллэх үндсэн индикатор болж чадна. Үндэсний давхар даатгал нь мэргэжлийн актуар тооцооллыг хийхдээ даатгуулагчаас зайлшгүй шаардлагатай мэдээ мэдээллийг заавал шаардаж авдаг учраас эрсдэлийг танин мэдэлгүйгээр “харанхуй” гэрээ байгуулж, хураамж цуглуулдаг буруу жишгийг халах нөхцөл болно.

Монгол Улсад даатгалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд үндэсний давхар даатгагчийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллага болон даатгалын салбарын оролцогчдын хамтын ажиллагааг уялдуулах, үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхойлох, даатгалын салбарын хяналтын тогтолцоог тодорхой болгож шинэчлэх, даатгалын сангийн хөрөнгийн менежментийг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн томоохон хөрөнгө оруулагч болоход дэмжлэг үзүүлэхэд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Иймд үндэсний давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний давхар даатгал ХК-д гадагш гарч буй давхар даатгалын гэрээ болгоны үнэлгээний 15-20 хувийг авч үлдэх заалт оруулах саналтай байна. */Үндэсний давхар даатгал ХК-ийн Андеррайтингийн ашиг, алдагдлын таамаглалын хавсаргав./*

Үндэсний давхар даатгал ХК-ийн Эрсдэл даах чадвар, нөөц сангийн чадамж болон алдагдлаас хамгаалах санд ирэх ачааллыг харгалзан үзээд давхар даатгалын зах зээлийн 25%-аас ихгүй хэмжээгээр эрсдэлийг шилжүүлэн авах боломжтой байна.

Даатгалын гэрээний 15 хувь буюу түүнээс бага хувийг дотооддоо авч үлдэх нь даатгалын үйл ажиллагаанаас гарах үр дүн багатай буюу гадагш гарах мөнгөн урсгалыг бууруулах, мэргэжлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, үнийн өрсөлдөөнийг хязгаарлах зорилгодоо бүрэн хүрч чадахгүй гэж үзэж байна. Харин даатгалын гэрээний 20 хувиас их хувийг дотооддоо авч үлдэхэд ҮДДХК-ийн эхний жил гарах алдагдал хэт өндөр байх тооцоолол гарч байна.

Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөр олгосон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмын дагуу алдагдлаас хамгаалах сангийн доод хэмжээний дүнг дахин бүрдүүлэхийн тулд давхар даатгалын хураамжийг боломжит хамгийн өндөр түвшинд төвлөрүүлэн авах хэрэгтэй. Иймд ҮДДХК-ийн хувьд даатгалын гэрээний 15-20 хувийг дотооддоо авч үлдэх боломжтой бөгөөд хамгийн зохистой хувилбар болно.

	<p>2. Энэ зүйлд “Үндэсний давхар даатгал” ХК гэж тусгайлан нэмж тусгах зайлшгүй шаардлагатай. Дотоодын давхар даатгалын компанид заавал давхар даатгуулахаар зохицуулбал гадаадын хөрөнгийн чадавх ихтэй хуулийн этгээд монгол улсад давхар даатгалын компани байгуулбал төрийн өмчийн оролцоотой Үндэсний давхар даатгал ХК түүнтэй хөрөнгийн хувьд өрсөлдөх боломжгүй болно. Олон улсын туршлагаас үзэхэд нэр зааж заавал давхар даатгуулах хуулийн шаардлагыг тусгаж өгдөг. Нөгөөтгээгүүр “Үндэсний” буюу “National” гэсэн тодотголтой аливаа аж ахуйн нэгж нь тухайн салбарынхаа стратегийн зорилтыг хангах дэд бүтэц болж, төрийн оролцоо дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг жишиг олон улсад нийтлэг байна. Манай улсын хувьд саяхан “МИАТ” ХК-ийг Үндэсний агаарын тээвэрлэгч гэх статустайгаар үйл ажиллагаагаа явуулдаг болсон жишээг дурдаж болно. Санал: 49.2. Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар даатгалд шилжүүлэх даатгалын үнэлгээний 15-аас доошгүй хувийг төрийн өмчийн оролцоотой Үндэсний давхар даатгал ХК-д заавал даатгуулна.</p>	
<p>2.</p>	<p>26.1 Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөхийг хориглоно. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж зааснаар Монгол улсын иргэн хувийн өмчтэй байх, хувийн өмчөө хуулиар хамгаалуулах эрхтэй бөгөөд өмчлөх эрхийг зөвхөн хуульд зааснаар хязгаарлаж болно. Энэ заалт Үндсэн хуулийн энэ үзэл санааг шууд зөрчсөн заалт болно. Жишээ нь: Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигч нь Сангийн яам. Сангийн яам өөрийнхөө хөрөнгийг захиран зарцуулахдаа Хорооноос заавал зөвшөөрөл авах шаардлага энэ хуулийн дагуу үүснэ. Үүнтэй нэгэн адил “Х” даатгалын компанийн хувьцаа эзэмшигч Дорж өөрийн өмчлөлийн хашаа байшингаа худалдахдаа Хорооноос зөвшөөрөл авах шаардлага үүснэ. Санал: хасах</p>	<p>Хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 26 дугаар зүйл нь "Даатгагчийн хувьцааны шилжилтэд тавих хяналт"-тай холбоотой зохицуулалт юм. Иймд тус заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулав. "26.1.Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшилд буй хувьцааг Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөхийг хориглоно."</p>
<p>3.</p>	<p>30.1.4 Аливаа этгээдийн бусдаас авсан зээл болон бусад үүргийн гүйцэтгэлд баталгаа, батлан даалт гаргах.</p> <p>Дэлхийн ихэнх хөгжингүй болон хөгжиж буй орнуудын даатгалын үйл ажиллагааны нийтлэг, жишиг бүтээгдэхүүн бол баталгаа юм.</p> <p>1. Баталгааны даатгалын ач холбогдол</p>	<p>Тийм. Саналыг тусгав.</p>

Баталгааны даатгал нь эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжих, импортыг орлох нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих төсөл болон аж ахуйн нэгжүүдэд өргөн хэрэглэгддэг бүтээгдэхүүн юм. Баталгааны даатгалыг олон улсад гадаад худалдаа эрхлэгчдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхээс гадна тухайн гэрээний оролцогч талуудад гэрээ, хууль тогтоомж, зах зээлийн талаар мэдээлэл өгөх, талуудын санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийх болон худалдааны гэрээний онцлогт тохируулан уян хатан шийдэл олоход тусалдаг.

Баталгааны даатгалын төрөлд гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааны даатгалын бүтээгдэхүүн багтах ба тус даатгалыг банкны бүтээгдэхүүнийг орлох өөр санхүүгийн үйлчилгээ хайж буй аж ахуйн нэгжүүд, мөн банканд баталгаа гаргуулахаар түгжигдсэн мөнгөө чөлөөлөн эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэн ашиглахыг хүссэн байгууллага, үйл ажиллагаагаа тэлэхийг зорьсон компаниуд ашиглах боломжтой. Мөн эх үүсвэргүй баталгаа шаардагдах үед зээл судлах хугацаа хэт удаан байх, мөн банкны тавьсан шаардлагыг хангах боломжгүй үед даатгал хийлгэн худалдаан оролцох боломжтой болно. Иргэдийн зах зээлийн хувьд ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн даатгалын бүтээгдэхүүн нь олон улсад түгээмэл даатгалын бүтээгдэхүүн бөгөөд энэ нь ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах зорилготой даатгалын баталгаа юм.

Олон улсад баталгааны даатгалыг ашиглахад дараах давуу талуудыг үүсгэдэг гэж үзсэн байна.

- Найдвартай байдал – гадаад худалдааны харилцаанд орж буй талуудад харилцан ашигтай байх,
- Хөрвөх чадвар – банканд барьцаа хөрөнгө, эх үүсвэр байршуулалгүй баталгаа гаргах боломжтой ба банкнаас барьцааг суллаж эргэлтийн хөрөнгөд ашиглах боломжтой,
- Экспортын өсөлт – шинэ зах зээл, шинэ харилцагчидтай эргэлзээгүй худалдаа эрхлэх,
- Харилцагч бүрд тохирсон үйлчилгээ – даатгуулагч аж ахуйн нэгжүүдийн бизнесийн онцлогт тохирсон гэрээ

2. Баталгаа, батлан даалт, баталгааны даатгал

Олон улсад ААН-үүд хил дамнан, эсвэл улс орон дотроо гэрээ байгуулан худалдаа, үйлчилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд guarantee /баталгаа/ болон surety /батлан даалт/ зэрэг санхүүгийн бүтээгдэхүүнийг ашиглан захиалагч, нийлүүлэгчийн эрсдэлийг хаан ажилладаг. Эдгээр 2 бүтээгдэхүүн нь оролцогч талууд гэрээний үүрэгт өөрөөр

	<p>оролцдог ч ерөнхийдөө ижил, бие биеэ орлох бүтээгдэхүүнүүд юм. Surety буюу батлан даалт нь захиалагч, нийлүүлэгч талын гэрээний салшгүй хэсэг болж ордог, тухайн батлан даасан этгээдийн үүргийг хамт үүрэлцэхийг хэлдэг бол guarantee буюу баталгааг гаргагч нь баталгаа дуудагдсан үед захиалагч талд төлбөр төлдгөөрөө ялгаатай.</p> <p>Батлан даалтын бүтээгдэхүүнийг аливаа улс орны Хөгжлийн банк, ЭКСИМ банк эсвэл экспортын зээлийн агентлагууд улсаас олгосон эрхийн дагуу тухайн орныхоо тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах, эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжих, импортыг орлох нэмүү өртөг шингэсэн. эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих төсөлд бодлогоор дэмжин гаргадаг байна.</p> <p>Харин баталгааг тухайн улсын хөгжлийн банк, эксим банкнаас гадна аливаа арилжааны банк гаргаж болдог.</p> <p>Гэтэл энэ заалтын дагуу Монгол Улсын даатгагч даатгалын баталгаа, батлан даалт гаргах боломжгүй болж байгаа нь зах зээлийн нийтлэг жишиг, хөгжлийн чиг хандлагаас зөрүүтэй зохицуулалт болж байгаа юм. Харин энэ заалтыг оруулахаар бол холбогдох этгээдийн гэж хязгаарлаж оруулж болохоор байна. Санал: 30.1.4 Холбогдох этгээдийн бусдаас авсан зээл болон бусад үүргийн гүйцэтгэлд баталгаа, батлан даалт гаргах.</p>	
<p>4.</p>	<p>91.3 Гомдол шийдвэрлэсэн шийдвэрийг даатгуулагч эс зөвшөөрсөн тохиолдолд Даатгалын омбудсманд гомдол гаргах эрхтэй талаар даатгагч нь даатгуулагчид мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>Арбитрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Монгол Улсад байнгын арбитрыг ... мэргэжлийн холбооны дэргэд байгуулж болно.” гэж заасны дагуу аливаа этгээд арбитрыг мэргэжлийн холбооны дэргэд байгуулах эрхтэй. Даатгалын хуулийн төсөлд мэргэжлийн холбоо гэсэн нийтийн эрх зүйн субъект орж байгаа тул түүний дэргэд дагнасан, мэргэжлийн арбитрыг байгуулж, түүгээр дамжуулан маргааныг шийдвэрлэх боломжтой. Омбудсманы хувьд хэрэгжих магадлал тун бага байна. Энэ өөрчлөлттэй холбоотойгоор энэ хуулийн төслийн 23 дугаар зүйлд мэргэжлийн холбоо дагнасан арбитрыг байгуулах эрх зүйн зохицуулалтын нэмж оруулах шаардлагатай.</p> <p>Санал:</p> <p>91.3 Гомдол шийдвэрлэсэн шийдвэрийг даатгуулагч эс зөвшөөрсөн тохиолдолд Даатгалын мэргэжлийн холбооны дэргэд байгуулсан дагнасан арбитрт гомдол гаргах эрхтэй талаар даатгагч нь даатгуулагчид мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>23.6 Даатгалын мэргэжлийн холбоо нь дэргэдээ даатгалын мэргэжлийн байнгын арбитртай байх бөгөөд түүний ажиллах журмыг Хороотой хамтран батална.</p>	<p>Үгүй. Хуулийн төсөл дэх маргаан шийдвэрлэх омбудсманы зохицуулалтыг хасав. Хэрэв гэрээнд арбитрийн заалттай бол шүүхээр маргаан шийдвэрлүүлэхгүйгээр арбитрын заалтаараа шийдвэрлүүлнэ.</p>

IV. “Монгол даатгал” ХК

<p>1.</p>	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах: Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн уг заалтад “Даатгалын хууль тогтоомж, даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалын гэрээний дагуу олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ” гэсэн байна. Энэхүү заалтыг “Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалын гэрээний дагуу олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.” хэмээн өөрчлөх саналтай байна. Учир нь “Даатгалын хууль тогтоомж, даатгалын гэрээнд заасан бол...” гэсэн нь даатгагчид хуулиар олгогдсон эрхийг нь хязгаарласан зохицуулалт болсон. Тодруулбал, даатгалын гэрээнд заагаагүй байсан ч Иргэний хуулийн 443 дугаар зүйлийн 443.7-д заасны дагуу даатгагч нөхөн төлбөрийг даатгуулагчид төлснөөр гуравдагч этгээдэд гаргаж болох шаардах эрх даатгагчид шилжинэ. Өөрөөр хэлбэл даатгалын гэрээнд зааснаас үл хамааран Иргэний хуулийн дагуу шаардах эрх даатгагчид шууд шилжинэ. Гэтэл даатгалын хууль тогтоомж болон даатгалын гэрээнд тухайн нөхцөлийг заавал тусгахаар заасан нь даатгагчид Иргэний хуулийн дагуу олгогдсон эрхийг нь хязгаарласан гэж үзэхээр байна. Харин даатгагч болон даатгуулагч “waiver of subrogation” буюу учирсан хохирлыг гэм буруутай гуравдагч этгээдээс нэхэмжлэхгүй байх тухай заалтыг даатгалын гэрээгээр харилцан тохиролцсон тохиолдолд л Иргэний хуулийн 443.7 дугаар заалт хэрэгжихгүй байх боломжтой тул Даатгалын тухай хуульд “...даатгалын гэрээнд заасан бол...” гэх хэсгийг “...даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол...” гэж өөрчлөх нь оновчтой гэж үзэж байна.</p>	<p>Үгүй. Гэрээнд заасан бол суброгаци хийгдэхээр зохицуулсан болно.</p>
<p>2.</p>	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9.4.1. дэх хэсэгт өөрчлөлт оруулах: Уг заалтыг “нөхөн төлбөр нэхэмжлэгчийн гаргасан өргөдөл, албан бичиг” болгон өөрчлөх саналтай байна. Учир нь даатгуулагч хуулийн этгээд байх тохиолдолд албан бичиг авах шаардлагатай байдаг.</p>	<p>Үгүй. Өргөдөл нь хүсэлт, шаардлага гэх мэт хүсэл зоригоо илэрхийлсэн бүхий л баримт бичгийг төлөөлөх агуулга учир, энэ хэвээрээ байх нь зохимжтой юм. Түүнчлэн, Хуулийн этгээдийн хувьд өргөдлийг албан бичгээр гаргах тул "албан бичиг" гэж нэмж тусгах шаардлагагүй.</p>
<p>3.</p>	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9.7.2. дахь хэсэгт өөрчлөлт оруулах: Даатгалын тохиолдлоос гадна даатгалын зүйлтэй холбоотой худал мэдээлэх, хуурамч бичиг баримт бүрдүүлэх боломжтой тул энэхүү заалтыг “даатгуулагч даатгалын зүйлийн талаар болон даатгалын тохиолдолтой холбоотойгоор</p>	<p>Тийм. Саналыг тусгав. "9.7.2.даатгуулагч даатгалын зүйл болон даатгалын тохиолдлын талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;</p>

	даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон” гэж өөрчлөх.	
4.	Сайн дурын даатгалын хураамжийн хувь хэмжээг тодорхой нэг түвшнээс доош оруулахгүй байх бодлого барих: Аль ч даатгалын компани тодорхой хувиас доош үнийн саналыг даатгуулагчид санал болгож болохгүй гэх агуулга бүхий зохицуулалт оруулж өгснөөр даатгалын салбарын тогтвортой хөгжих, даатгалын компани хоорондын шударга өрсөлдөөнийг бий болгох давуу талтай гэж үзэж байна.	Үгүй. Сайн дурын даатгалын хураамжийн тооцооллыг даатгагч өөрөө актуар тооцоололд үндэслэн гаргана. Энэхүү бизнесийн үйл ажиллагаанд Хороо оролцож холбогдох шаардлагыг тавих боломжгүй бөгөөд мэргэжлийн холбооноос баталсан ёс зүйн дүрэмд энэ талаарх зохицуулалтыг оруулах боломжтой.
5.	Санхүүгийн тайлагналын хугацааг НББ тухай хууль, ААНОАТ-н тухай хуулиудтай уялдуулж, хагас бүтэн жилээр тайлагнах байдлаар Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 67.1-д өөрчлөлт оруулах	Үгүй. НББ-ийн тухай хуулийн "9.7.Аж ахуйн нэгж, байгууллага нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно.", Аудитын тухай хуулийн "10.2.3.банк жилийн эцсийн санхүүгийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор;", "10.2.4.бусад аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн жилийн тайланг дараагийн санхүүгийн жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор." гэж тус тус заасан байдаг. Хуулийн төсөлд санхүүгийн тайланг 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор гаргахаар тусгасан бөгөөд үүнээс улбаалан аудитаар баталгаажуулсан тайланг 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлэх боломжтой тул саналыг тусгах боломжгүй.
6.	ААНОАТ-н тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах: 11.1 ААНОАТ-н хуулийн 11.1.1-д даатгалын нөхөн төлбөрийг бусад орлогод хамааруулсан. Угтаа нөхөн төлбөр нь орлого бус, даатгалын гэрээний дагуу аливаа эдийн болон эдийн бус хохирлыг барагдуулж буй олговор юм. Иймд даатгалын нөхөн төлбөрийг бусад орлого хэсгээс хасах шаардлагатай гэж үзэж байна. 11.2 ААНОАТ-н тухай хуульд давхар даатгалын хураамжийн орлогоос татвар авна гэж тусгайлан заагаагүй ч практикт 5.5.1, 5.5.2, 7.2, 7.3-р зүйл заалтуудад тулгуурлан 20%-	Үгүй. Даатгалын салбар дахь татварын асуудлууд нь хуулийн төслүүд болон дагалдах хуулийн төслүүдэд хамаараагүй болно. ААНОАТ-н тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах талаар хэлэлцүүлэг, уулзалтууд хийгдэж байна.

	<p>ийн татвар төлөхийг Татварын газраас шаарддаг. Даатгагчид томоохон дүнтэй даатгалын гэрээний хариуцлагыг ихэвчлэн 100% давхар даатгалд шилжүүлдэг. Нэмж 20%-ийн татвар төлөх нь даатгагч тухайн гэрээг байгуулснаар шууд алдагдал хүлээхэд хүргэж байна.</p> <p>11.3 ААНОАТ-н тухай хуулийн 13.2.7-д “Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчийн харилцан хамааралтай этгээдтэй хийсэн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15%-с хэтрэхгүй байх”-аар хязгаарласан байна. Энэхүү хязгаарлалтыг хасаж, даатгалын хураамжийн хязгаарлалт тавихгүйгээр тайлант жилийн зардал гэж хүлээн зөвшөөрдөг байх саналтай байна.</p>	
7.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10.2.7 дахь хэсгийг хасах: Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10.2.7-д зааснаар эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон даатгуулагчийн хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавихыг даатгагчид үүрэг болгосон нь зохимжгүй байх бөгөөд шаардлагагүй зохицуулалт байна.</p>	<p>Үгүй. Энэхүү зохицуулалт нь амьдралын даатгалтай холбоотой заалт бөгөөд даатгуулагч эрх зүйн чадамжгүй болсон тохиолдолд, даатгалын гэрээний харилцааг үргэлжлүүлэх, гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх эсэх зэрэг асуудлууд үүсэх юм. Үүнтэй холбоотойгоор даатгагч үүргээ гүйцэтгэх, эсхүл эрхээ хэрэгжүүлэхийн тулд харгалзан дэмжигчийг тогтоолгох зэрэг процессыг шуурхай явуулах агуулгатай нэг талаараа даатгагчид эрх олгосон заалт юм.</p>
8.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22.5.3 дахь хэсгийг хасах: Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22-р зүйлийн 22.5-д “Заавал даатгалын холбооны хөрөнгийн эх үүсвэр”-ийг зохицуулсан байх бөгөөд 22.5.3-т ”мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого” гэсэн байна. Мөн хуулийн төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэгт “Даатгалын мэргэжлийн оролцогчид нь хууль тогтоомжид заасан холбогдох мэдээллийг даатгалын мэдээллийн санд төвлөрүүлэх үүрэгтэй” хэмээн зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, даатгалын мэргэжлийн оролцогч нь даатгалын мэдээллийн санд мэдээллээ нийлүүлээд, нийлүүлсэн мэдээллээ эргээд төлбөртэй ашиглахаар байгаа нь зүйд нийцэхгүй бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх ашгийг зөрчсөн зохицуулалт болсон байна. Иймээс уг заалтыг хуулийн төслөөс хасах саналтай байна</p>	<p>Хэсэгчлэн тусгав. Төслийн "70.3. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх, хуваарилах, боловсруулах, удирдах, ашиглуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Хороо батална." гэж заасан байгаа уг журмаар мэдээллийн санг ашиглахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.</p>
9.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22.5.4 дахь хэсгийг хасах.</p>	<p>Үгүй. Заалтыг хасах үндэслэлийг ирүүлээгүй байна. Хуулийн төслийн 22.1.3-т заавал даатгалын чиг үүргийг "заавал даатгалын эрсдэл, хураамж болон үнэлгээний доод</p>

		хэмжээг тогтоох талаар судалгаа хийх, итгэлцүүр тогтоох саналаа Хороонд хүргүүлэх" гэж тодорхойлсон. Иймд холбогдох актуар тооцоолол хийх байдлаар илүү мэргэшиж ажиллавал зах зээлийн хөгжилд түлхэц болно гэж харж байна.
10.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 35.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах: Энэхүү заалтын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хугацааг “дараа оны эхний сард” гэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалттай уялдуулан “дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор” гэж өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Уг заалтад “жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Даатгалын журамд заасан бичиг баримтын хамт дараа оны эхний сард багтаан Хороонд хүргүүлнэ” гэж жилийн тайлангийн хугацааг наашлуулсан нь салбар нэгжийн нэгтгэл хийх, наадам, цагаан сар бүх нийтээр амрах өдөртэй давхцадаг зэрэг шалтгаанаар арай хийж л хуулийн хугацаанд багтаадаг байсан нөхцөл байдал улам хүндрэх, алдаа залруулга гарах магадлалыг улам өсгөх нөхцөлд хүргэж байна.</p>	<p>Үгүй. Даатгал нь эрсдэлийг шилжүүлэн авч, ирээдүйд төлөх нөхөн төлбөрт зориулан даатгалын хураамж төвлөрүүлэн, түүгээрээ даатгалын нөөц сан бүрдүүлдэг онцгой зохицуулалт шаардсан санхүүгийн салбар. Тиймээс эрсдэлийг тухай бүр тооцоолох шаардлагатай бөгөөд энэ ч утгаараа хамгийн нарийн төвөгтэй тооцоолол болох даатгалын нөөц сангийн тооцооллыг өдөр бүр гаргах боломж даатгагчид бүрдсэн. Банкны тухай хуулийн дагуу банк санхүүгийн тайлангаа 1 дүгээр сард багтаан Монгол банканд ирүүлдэг. Даатгал бол банкнаас илүү өдөр бүр эрсдэлээ тооцоолох шаардлагатай төдийгүй программ хангамжийн хувьд хангалттай туршлагыг хуримтлуулсан тул даатгалын компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланг 1 дүгээр сард багтаан авах боломжтой юм.</p>
11.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 70.1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах: Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 70.1 дэх хэсэгт “Даатгалын мэдээллийн санг удирдах этгээд нь Заавал даатгалын холбоо байна.” гэж заасан байна. Заавал даатгалын холбооноос нийт даатгалын мэдээллийн санг удирдах нь зохимжгүй, хэт эрх, хэмжээ олгосон байх тул Заавал даатгалын холбоо зөвхөн заавал даатгалтай холбоотой санг удирддаг байхаар хуульд зохицуулах шаардлагатай.</p>	<p>Тийм. Заавал даатгалын холбоо нь өөрийн хамаарах заавал даатгалын хүрээнд даатгалын мэдээллийн санг удирдах боломжтой тул саналыг тусгах боломжтой.</p>
12.	<p>Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 49.2 дэх хэсэгт өөрчлөлт оруулах: Төслийн 49.2 дахь хэсэгт “Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар даатгалд шилжүүлэх даатгалын үнэлгээний 10-аас доошгүй хувийг энэ хуулийн 49.1.1-д заасан даатгагчид даатгуулна” гэж заасан</p>	<p>Хэсэгчлэн тусгав. Даатгалын компаниуд 2019-2023 оны хооронд хураамжийн нийт орлогын 34.0 хувийг буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн</p>

	<p>байна. Энэхүү заалт нь өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй мөн хувийг хэт хатуу тогтоож өгсөн хэрэгжилт нь хүндрэлтэй зохицуулалт байх тул хасах саналтай байна. Манай компанийн хувьд дотоодын давхар даатгагчтай хамтран ажилладаг бөгөөд үүнийг заавал хатуу хувь хэмжээ зааж хуульд тусгах шаардлага байхгүй гэж үзэж байна. Иймд уг заалтыг хуулийн төслөөс хасах эсвэл “даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар даатгалд шилжүүлэхдээ давхар даатгагчаас урьдчилан санал авч зөвшөөрсөн тохиолдолд даатгалын үнэлгээний 10-аас доошгүй хувийг энэ хуулийн 49.1.1-д заасан даатгагчид даатгуулна” гэж өөрчлөх саналтай байна.</p>	<p>нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна. Олон улсын туршлагыг судалж үзвэл: ОХУ-ын хуульд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг заавал даатгуулдаг. Беларусь улс Belarus Re төрийн өмчит давхар даатгалын компанийг 2006 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2006 онд 10 хувь, 2007 онд 20 хувийг шилжүүлдэг болгож, хуульд нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байгаа. Хуульд зааж өгсний үр дүнд бүх давхар даатгалын гэрээ тус байгууллагаар дамждаг болж хяналт хийгдсэний дагуу Үндэсний давхар даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгож чадсан байна. Энэтхэгийн ердийн даатгалын компаниуд давхар даатгалынхаа 10 хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, 5 хувийг заавал шилжүүлэх зохицуулалттай байна. Эндээс харахад ихэнх улсууд давхар даатгалын зах зээлийг төрийн дэмжлэгтэйгээр эхэлж өргөжүүлээд, үүнийхээ дараа алхам алхмаар оролцоогоо бууруулах боломжтой юм.</p>
13.	<p>Заавал даатгалын холбооны удирдлагыг сонгон шалгаруулах журам, удирдлагад тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулах.</p>	<p>Үгүй. Төслийн 22 дугаар зүйл дээр Заавал даатгалыг холбооны чиг үүрэг, гишүүнчлэл, удирдлага, зохион байгуулалтыг тодорхой зааж өгсөн.</p>
<p>V.Монголын Даатгалын холбоо</p>		
1.	<p>4.1.1."даатгалын үйл ажиллагаа" гэж даатгалын гэрээ байгуулж, хураамжийн орлого төвлөрүүлэх, даатгалын нөөц санг бүрдүүлэх, түүний зохистой байдлыг хангах, даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;</p>	<p>Үгүй. Даатгалтай холбоотой бүхий л үйл ажиллагааг тодорхойлолтод нарийн тодорхойлох шаардлагагүй. Төслийн 54.2-т "Даатгагчийн эрхлэх даатгалтай холбоотой үйл ажиллагааг Даатгалын журмаар тодорхойлж болно." гэж заасан тул журмаар тодорхойлох боломжтой. Хөрөнгө оруулалтын</p>

		үйл ажиллагааг тодорхойлолтод багтаах эсэх талаар мөн судлах.
2.	4.1.6.“заавал даатгал” гэж Монгол Улсын хуульд даатгуулахаар тусгагдсан даатгалын үйл ажиллагааг;	Үгүй. Энэхүү хуулийн төслөөр "Заавал даатгал" гэсэн тодорхойлолтыг оруулж байгаа бөгөөд хэрэгжилтийг хангахад заавал даатгуулахаар тусгах нь зүйтэй.
3.	4.1.11."даатгалын нөхөн төлбөр" гэж даатгалын гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагч, эрх ашиг нь даатгагдсан гуравдагч этгээд болон хохирогчид олгох мөнгөн хөрөнгө.	Тийм. Саналыг дараах байдлаар тусгав. 4.1.11."даатгалын нөхөн төлбөр" гэж даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг"
4.	4.1.12. “даатгалын мэргэжлийн оролцогч” гэж даатгагч, даатгалын брокер, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч,	Хэсэгчлэн тусгав. Даатгалын мэргэжлийн оролцогч гэж зөвхөн даатгагч, даатгалын брокер, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч биш бөгөөд даатгалын салбарт оролцож буй бүхий л мэргэжилтнүүдийг хэлэх бөгөөд тусгайлан Хорооноос тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх авч буй мэргэжилтнүүдийг дурдах нь зүйтэй. Харин даатгагч, үүний цаана бүх мэргэжилтнүүд орох тул андеррайтерийг хасах боломжтой.
5.	6.2.3 Эрүүл мэнд, эмчилгээний зардлын даатгал. Хасах саналтай байна. Үндэслэл: Бизнесийн байгууллагын бүтээгдэхүүний төрөл, хэлбэрийг хуулиар хүрээ тогтоож зохицуулах нь өрөөсгөл бөгөөд бусад санхүүгийн салбарын хуулиуд болон гадаад улсын хуулиудад тэгж тодорхойлж, тогтсон жижиг байхгүй.Зөвхөн даатгагдах эрсдэлийг тогтоож зааж өгсөн байхаар байна.	Үгүй. Төсөлд 6.2.3 гэсэн заалт байхгүй бөгөөд ирүүлсэн санал тодорхой бус байна. Төслийн 4.1.4 болон 4.1.5-д даатгалын ангиллын тодорхойлолтыг тодорхой оруулж өгсөн бөгөөд үүнд амьдралын даатгалд эрүүл мэндийн даатгал орохоор заасан бөгөөд ердийн даатгал нь амьдралын даатгалд хамрагдаагүй даатгалыг хийнэ гэж заасан.
6.	7.3 Хасах саналтай. Арилжааны байгууллагын үйл ажиллагаанаас нийгмийн хариуцлагын шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлэх санг хуульд тусгайлан зааж өгөх нь өрөөсгөл бөгөөд байж болохгүй заалт байна.	Хэсэгчлэн тусгав. Төслийн 7.3-т заасан сангийн тухайд тусгайлсан сан байгуулалгүйгээр даатгалын компани заавал даатгалын хураамжийн орлогын тодорхой хувийг байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнес, үйл ажиллагаандаа зарцуулахаар өөрчлөн

		<p>найруулав. УИХ-аас 2020 онд баталсан "Алсын хараа2050"-ын Зорилго 6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна. гэж заасан. Тогтвортой санхүүгийн зарчим, санаачлагуудыг “албан” болон “сайн дурын” гэж ангилдаг.</p> <p>и Албан: Тухайн улсын төв банк, зохицуулагч байгууллага болон эрх бүхий байгууллагын гаргасан хууль эрхзүй, зохицуулалтын шаардлагын дагуу үйл ажиллагаандаа заавал нэгтгэсэн байх бодлого, арга хэмжээ</p> <p>и Сайн дурын: Санхүүгийн байгууллага өөрийн бодлоготойгоо уялдуулан тогтвортой санхүүг сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд туслах олон улсын сайн туршлага, зарчмуудыг тусгах байдлаар хэрэгждэг. Иймд энэхүү зорилгыг биелүүлэхэд хүн бүрийн оролцоо чухал.</p>
7.	8.3 Заавал даатгалын хураамж тооцох итгэлцүүр, түүний аргачлалыг Санхүүгийн зохицуулах хороо тогтоох бөгөөд 2 жилд нэг удаа даатгалын мэргэжлийн хөндлөнгийн байгууллагын зөвлөмжид (Актуарчийн нийгэмлэг гэх мэт) үндэслэн шинэчлэн тогтооно.	<p>Үгүй. Төслийн 7.2-т "Энэ хуулийн 7.1-д заасан заавал даатгалын үйл ажиллагааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулаагүй бол заавал даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, заавал даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг Хороо, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан журмаар нарийвчлан зохицуулна" гэж заасан. Үүний дагуу даатгалын үнэлгээ хураамжийг тухай бүр тогтоох нь зүйтэй.</p>

8.	9.4.3 хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад баримт	Үгүй. Хууль тогтоомжид зааснаас өөр бичиг баримт шаардаж болохгүй. Хууль тогтоомж буюу журмаар зохицуулах боломжтой
9.	Хасах саналтай байна. Даатгагчийн хувьд даатгалын туйлын үнэнч шударга зарчим болон нөхөн төлбөрийн зарчмыг үндэслэн тухайн даатгалын тохиолдолтой холбогдох мэдээллийг шаарддаг.	Үгүй. Даатгагч даатгалын гэрээг даатгуулагчид борлуулж байгаа. Туйлын үнэнч зарчмын хувьд даатгагч нь ил тод, үнэн мэдээллийг өгөх шаардлагатай. Гэтэл даатгагч гэрээнд тусгаагүй материалыг даатгуулагчаас шаардах нь шударга бус бөгөөд даатгуулагчийг хохироох, даатгуулагч даатгалд итгэх итгэлийг үгүй болгох үндэслэл болно.
10.	9.5 Хасах саналтай. Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа нь даатгагчийн болон даатгуулагчийн гэрээний эрх зүйн харилцаагаар тодорхойлогдох бөгөөд энэхүү харилцааг журмаар зохицуулах нь хэт даатгагчийн үйл ажиллагааг хязгаарлах зохицуулалт болно.	Үгүй. Даатгалын багц дүрмийн 1 хавсралт журамд даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа бөгөөд нөхөн төлбөрийн журмын хувьд даатгалын тулгуур зарчмуудыг голлон тусгана.
11.	9.6.даатгуулагч даатгалын нөхөн төлбөр авах зорилгоор санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг зохиомлоор бүрдүүлсэн. гэж өөрчлөх. Үндэслэл: ЭХ-ийн 18.15-д зааснаар нөхцөл байдлыг мэдсээр байж нөхөн төлбөр олгосны дараа хэрэг үүсгэх, тогтоох ажиллагаа явагдах болчихоод байна.	Тийм. Саналыг тусгав.
12.	9.7.2.даатгуулагч даатгалын гэрээ байгуулах үед болон даатгалын тохиолдлын талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;	Хэсэгчлэн тусгав. Дараах байдлаар тусгав. "Даатгалын зүйл болон даатгалын тохиолдлын талаар санаатайгаар худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн". Саналд тусгасны дагуу "даатгалын гэрээ байгуулах үед" гэж тусгавал хэт ерөнхий, юуны талаар худал мэдээлэх нь тодорхой бус байна.
13.	9.9. Хасах саналтай байна.Даатгалын журмаар зохицуулах боломжтой.	Тийм. Журмаар зохицуулах боломжтой тул хасав.
14.	9.10.9 Хасах саналтай байна. ИХ-ийн 443.7-д заагдсан гэрээний харилцааны заалтыг	Үгүй. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн заалт бөгөөд саналд тусгасан ИХ-

	энэ хуульд тусгах нь давхардаж байна.	ийн 443.7-д заасан гэрээний харилцаа нь зөвхөн гэм хорын даатгалд хамаарахаар байна.
15.	9.11. Даатгалын тохиолдлын улмаас хөрөнгө бүрэн утсан, сүйрсэн, дахин сэргээгдэх боломжгүй болсон тохиолдолд учирсан хохирлыг даатгагч бүрэн барагдуулсан бол даатгуулагч болон хохирогч нь уг хөрөнгийг даатгагчид шилжүүлнэ.	Тийм. Саналыг тусгав.
16.	10.1.5 Даатгалын тохиолдлыг шалган баталгаажуулах зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг гаргуулан авах; Хасах саналтай байна. Хуульд тусгасан тусгаагүй хийгддэг үйл ажиллагаа.	Тийм. Саналыг тусгав.
17.	Хасах саналтай байна. Энэ харилцааг даатгагч, төлөөлөгч харилцан зохицуулах боломжтой Нөгөөтэйгүүр "Зуучлалын тухай хууль"-нд арилжааны банкиг төлөөлөгч статусаар тусгай зөвшөөрөл олгох бол энэ заалт нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцлагыг даатгагчид шилжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцлага үүрэхгүй байхаар заасан байна.	Үгүй. Зүйл заалт тодорхойгүй.
18.	13.2.1. холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах; Үндэслэл: СЯ-тай давхацсан чиг үүрэг	Үгүй. Аль аль байгууллага санал гаргах эрхтэй байхаар тусгасан. Хуулийн хэрэгжилтийг хангуулахад давхцах зүйл гарахгүй.
19.	13.2.8 Хасах саналтай байна. Үндэслэл: Даатгагч даатгуулагч 2 талын гэрээний харилцаанд зохицуулах байгууллага хөндлөнгөөс оролцож шүүхэд нэхэмжлэл гаргах нь буруу.	Тийм. Саналын дагуу хасав.
20.	14.2.5.Хасах саналтай байна. Үндэслэл: 1. Даатгагч нь Монгол улсад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг авсан атал салбар, төлөөлөгчийн газар нээх бүрд дахин зөвшөөрөл авах нь буруу. 2."Цахим үндэстэн" гэх төрийн бодлого хэрэгжиж байхад заавал "бодит" салбарыг байгуулж зардал гаргаснаар тухайн бүс нутагт даатгалын үйл ажиллагаа явуулна гэдэг өрөөсгөл чиг хандлага байна.	Хэсэгчлэн тусгав. Энэхүү журам нь Гадаадын даатгагч монгол улсад салбар нээхтэй холбоотой харилцааг зохицуулах тул журмын нэрийг тодотгох боломжтой.
21.	14.2.6.Хасах саналтай байна. Үндэслэл: Бизнесийн ёс зүй кодексыг мэргэжлийн холбоо хэрэгжүүлэх боломжтой. Төрийн байгууллага хууль хэрэгжүүлэхэд хяналт, зохицуулалтдаа анхаарах нь зүйтэй.	Тийм. 21.1.2-т гишүүдийнхээ үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, заавар, зөвлөмжийг баталж, хэрэгжилтийг хангуулах; гэж мэргэжлийн холбооны эрхэд оруулсан тул хасав.
22.	14.3 Хасах саналтай байна. Үндэслэл: Зохицуулах байгууллага нь хуульд зааснаас бусад зохицуулалтын журмыг бий болгох нь хэт субъектив хандлагыг бий болгох эрсдэлтэй. Түүнчлэн СЗХ-ны Эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2.-т тодорхой заасныг давхардуулан энэ хуульд заалт оруулах нь өрөөсгөл байна.	Үгүй. ИСР 19 буюу Даатгалын тулгуур зарчим 19-д "Зохицуулагч байгууллага нь даатгагчид, даатгалын зуучлагчдаас өөрсдийн бизнесийн соёлын хэсэг болгон хэрэглэгчдэд шударга хандахад чиглэсэн хэрэгжүүлэх бодлого,

		журмыг бий болгож, хэрэгжүүлэхийг шаардана." гэж тусгасан байдаг. Хэдийгээр Хороонд даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиг үүрэг байхгүй ч гэлээ өдөр өдрөөр өөрчлөгдөж буй нөхцөл байдалтай холбоотойгоор зах зээлийг дэмжих, даатгуулагч, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтын журам гарах зайлшгүй шаардлага бий болж болно.
23.	16.3 Хасах саналтай байна. Үндэслэл: Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.2 заалтаас гадуур бичиг баримт шаардах үндэслэл болохоор байна.	Хэсэгчлэн тусгав. Өргөдөл гаргагчаас хүсэх баримт болгоныг хуульд тусгах боломжгүй. Өөрөөр хэлбэл, шинэ төрлийн баримт хүсэх болгонд хуульд нэмэлт оруулах боломжгүй учраас, баримтын жагсаалтыг журмаар батална. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд тогтоолоор журам батална. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан процессын дагуу боловсруулж, олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг шаардлагатай бүх шатны арга хэмжээг авсны үндсэн дээр баталж, ХЗДХЯ-нд бүртгүүлдэг тул журамд зааснаас гадуур баримт бичиг шаардах боломжгүй болно.
24.	17.1 Хасах саналтай байна. Үндэслэл: Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.2 заалтаас гадуур бичиг баримт шаардах үндэслэл болохоор байна.	Хэсэгчлэн тусгав. Хорооны шаардлага болгоныг хуульд тусгах боломжгүй. Өөрөөр хэлбэл, шинэ төрлийн шаардлага тавих болгонд хуульд нэмэлт оруулах боломжгүй учраас, шаардлагын жагсаалтыг журмаар баталдаг байна.
25.	17.7.2 Хасах саналтай байна. Үндэслэл: Тодорхойгүй заалт байна. Шаардлага хангаагүй гэдэг тухайн нөхцөлд хувь хүнээс хамаарсан субъектив хандлага гаргах боломжтой.	Үгүй. Даатгалын журамд холбогдох баримт бичгийн жагсаалтыг гаргасан байх бөгөөд ямар тохиолдолд шаардлага хангах талаар тодорхой зааж өгсөн байдаг. Иймд энэхүү заалт нь зайлшгүй шаардлагатай.

26.	17.8. Хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгагчийн тусгай зөвшөөрлийг ажлын 45 хоногт олгох эсэхийг шийдвэрлэнэ. (Даатгагчаас бусад тусгай зөвшөөрөл дээр ажлын 45 хоног гэсэн уян хатан бус байдлыг өөрчлөх хэрэггүй байна.)	Хэсэгчлэн тусгав. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан холбогдох өөрчлөлтийг оруулсан.
27.	19.2. Хасах саналтай байна. Журмаар зохицуулах боломжтой. Үндэслэл: Давхар даатгалын төлөвлөгөөг СЗХ-ны дагуу олон шатлалт процессыг хэрэгжүүлж, СЗХ-нд хүлээлгэж өгсний дараа аливаа хэрэглээ байхгүй байгаа учраас хуульд заах нь учир дутагдалтай байна. Шаардлагатай тохиолдолд СЗХ шаардаж танилцах эрх байгаа гэж үзэж байна.	Үгүй. Төлөвлөгөөнд давхар даатгалыг тусгасан бол заавал тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулах /19.1/ шаардлага хамаарахгүй байх заалт юм.
28.	<p>"20 дугаар зүйл. Мэргэжлийн холбоо</p> <p>20.1. Энэхүү хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагч нь сайн дурын үндсэн дээр даатгалын салбарын мэргэжлийн холбоонд гишүүн болж болно.</p> <p>20.2. Мэргэжлийн холбоо нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн зохицуулалттай байх бөгөөд уг холбооны удирдах зөвлөлд даатгагч болон хараат бус гишүүний төлөөллийг оролцуулна.</p> <p>20.3. Мэргэжлийн холбоо нь хууль тогтоомжид нийцсэн дүрэмтэй байна.</p> <p>20.4. Мэргэжлийн холбоо нь заавал даатгалын үйл ажиллагаанаас хамаарсан хохирогчийн эрхийг сэргээх зориулалт бүхий даатгагчдын дундын нөөц санг байгуулж ажиллана.</p> <p>20.5. Мэргэжлийн холбоо нь даатгагчийн болон түүний эрх бүхий албан тушаалтантай холбоотой тусгай зөвшөөрлийн болон бусад мэргэжлийн бүхий л сургалтыг дангаар болон бусад этгээдтэй зохион байгуулна.</p> <p>20.5. Мэргэжлийн холбоо нь ёс зүйн кодекстэй байх бөгөөд гишүүд нь кодексыг заавал дагаж мөрдөнө.</p> <p>20.6. Мэргэжлийн холбоо нь салбарын нэгдсэн мэдээллийн сантай байх бөгөөд мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж, жил бүр мэдээллийн сангийн аудитыг хийлгэнэ."</p> <p>Үндэслэл: 1. Заавал даатгал гэх тухайлсан онцлог даатгалын үйл ажиллагааны ойлголт байхгүй бөгөөд даатгагдах эрсдэлийг холбогдох салбарын хуулиудад тусгасны дагуу энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид шилжүүлэх үйл ажиллагаа юм. 2. Салбарын хуулиудад заавал даатгуулах эрсдэлийг тогтоож өгсөн бөгөөд Заавал даатгал гэх тусдаа тогтолцоог зааж өгөөгүй болно. 3. Мэргэжлийн холбоог гишүүдийн оролцоотой байгуулдаг атал төрийн байгууллага төрийн бус байгууллага статустай байгууллагыг байгуулж, хөрөнгөжүүлэх эрхийг хуулиар олгож, мөн зохицуулалтын</p>	<p>Хэсэгчлэн тусгав. Хуулийн төсөлд шинээр тусгасан Баталгаат сан, Мэдээллийн сан зэрэг зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд үйл ажиллагаа тогтворжсон тохиолдолд мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх боломжтой.</p> <p>Харин тус Заавал даатгалын холбооны засаглалд төр, хувийн хэвшил, мэргэжлийн бусад холбоодын үүрэг ямар байх талаар санал ирүүлбэл тусгах боломжтой байна.</p>

	<p>зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ гэх төрийн бодлогыг хуулиар төрийн бус байгууллага байгуулж түүндээ шилжүүлж байгаа нь чухам үнэндээ зарим чиг үүргээ шилжүүлэх зарчим огтоос биш байна. Учир иймд мэргэжлийн холбоог зах зээлд нь үлдээж харин түүний засаглалыг сайжруулахад хөндлөнгийн хараат бус гишүүнийг томилох замаар чадавхжуулах, төрийн бус байгууллагаас улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг холдуулах бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. 4. Одоогийн АЖДХ-нд төвлөрсөн төсвийн хөрөнгийг Баталгаат сан буюу "Safety Net" болгож зохион байгуулах, гишүүд нь сангаа хөрөнгөжүүлэхэд анхаарах талаарх зохицуулалтыг тусгах. 5.Мэргэжлийн холбооны чиг үүргүүд болох мэдээллийн сан, шуурхай алба, нийгмийн шинжтэй эрсдэлийг бууруулах, ёс зүй кодексыг хэрэгжүүлэх, олон нийтийг даатгалжуулах мэдлэг олгох, мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгөх ажлуудыг төвлөрүүлэх нь зүйтэй болно. Дээрх чиг үүргүүдийг Мэргэжлийн холбоонд төвлөрүүлж, холбогдох хяналтыг хийх нь зөв болов уу.</p> <p>20.2.1. Хасах саналтай байна. Төрийн байгууллага, төрийн бус байгууллагад үүрэг даалгавар өгөх боломжгүй.</p> <p>Хасах саналтай байна. Төрийн байгууллага, төрийн бус байгууллагад үүрэг даалгавар өгөх боломжгүй.</p>	
29.	<p>22 дугаар зүйл. Хасах саналтай байна. Үндэслэл: 20.2.1-тэй адил.</p> <p>23.3.Хасах саналтай байна. Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шаардлага тавих бүрэн эрхтэй.</p>	Хэсэгчлэн тусгав. Дараах байдлаар тусгав. "23.2. Хороо нь дараах шаардлагыг хангасан даатгалын мэргэжлийн холбоотой захиргааны гэрээг байгуулж, чиг үүргээ шилжүүлж болно".
30.	23.4.Хасах саналтай байна. Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд зохицуулалт, хяналт хийх шаардлагатай.	Тийм. Саналыг тусгав.
31.	23.5. Хасах саналтай байна. Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд зохицуулалт, хяналт хийх шаардлагатай.	Үгүй. Хороо чиг үүргээ шилжүүлэх тул Хорооноос олон нийтэд мэдээлэх эрхтэй гэж үзэж байна.
32.	26.1. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд нь энэхүү хувьцаагаа Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөхийг хориглоно. Хороо хувьцаа худалдан авч буй этгээдийн зөвхөн мөнгөний эх үүсвэрийг шалган тогтоож зөвшөөрөл олгоно.	Хэсэгчлэн тусгав. ҮДДК ирүүлсэн саналтай давхардсан. Дараах байдлаар тусгав. 26.1.Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээд нь өөрийн өмчлөл, эзэмшилд буй хувьцааг Хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах

		зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөхийг хориглоно. гэж өөрчлөх
33.	26.5. Хасах саналтай. Бусад нөхцөл, шаардлага гэдэг тодорхойгүй байна. Тодорхой бус ийм шаардлага, нөхцөлийг үүсгэх эрхийг хасах.	Хэсэгчлэн тусгав. Хорооны шаардлага болгоныг хуульд тусгах боломжгүй. Өөрөөр хэлбэл, шинэ төрлийн шаардлага тавих болгонд хуульд нэмэлт оруулах боломжгүй учраас, шаардлагын жагсаалтыг журмаар баталдаг байна. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд тогтоолоор журам батална. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан процессын дагуу боловсруулж, олон нийтээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг шаардлагатай бүх шатны арга хэмжээг авсны үндсэн дээр баталж, ХЗЯ-д бүртгүүлдэг тул журамд зааснаас гадуур баримт бичиг шаардах боломжгүй болно.
34.	28.1. Даатгагч нь гэрээний явцад үүссэн болон үүсэж болзошгүй үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын хураамж, нэхэмжлэлийн онцлогийг харгалзан даатгалын нөөцүүдийг даатгалын төрөл тус бүрээр байгуулж, хөрөнгөөр бүрдүүлнэ.	Үгүй. Даатгалын хураамж мөнгөн хөрөнгөөр орж ирдэг. Даатгалын хураамжаас байгуулж буй нөөц санг анх байгуулахдаа мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх ёстой бөгөөд цаашид даатгалын нөөц сан нь даатгалын гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах буюу даатгалын нөхөн төлбөрт зарцуулагдах тул хөрвөх чадвартай, богино хугацаат хөрөнгө оруулалтад байршуулж болох талаар журмаар зохицуулах боломжтой.
35.	30.1.4. Хасах саналтай байна. PMI, болон гүйцэтгэлийн баталгаа нь даатгалын мөн чанарт хамаарах ойлголт. Энэ чиглэлээр холбогдох хуулиудад даатгалын баталгааг оруулахаар ажлууд хийгдэж байна.	Хэсэгчлэн тусгав. Саналын дагуу уг заалтыг хасах боломжгүй бөгөөд дараах байдлаар тусгав. "30.1.4.холбогдох этгээдийн бусдаас авсан зээл болон бусад үүргийн гүйцэтгэлд баталгаа, батлан даалт гаргах"

36.	33.4. Хасах саналтай. Хуульд бус журмаар зохицуулж болохоор байна.	Хэсэгчлэн тусгав. Дараах байдлаар тусгав. "33.4.Энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээд нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хугацаагаар хадгална"
37.	35.1. Энэ хуулийн 33.1-д заасан хуулийн этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Даатгалын журамд заасан бусад бичиг баримтын хамт дараа оны эхний 2 дугаар сарын 10-ны дотор багтаан Хороонд хүргүүлнэ.	Үгүй. Даатгал нь эрсдэлийг шилжүүлэн авч, ирээдүйд төлөх нөхөн төлбөрт зориулан даатгалын хураамж төвлөрүүлэн, түүгээрээ даатгалын нөөц сан бүрдүүлдэг онцгой зохицуулалт шаардсан санхүүгийн салбар. Тиймээс эрсдэлийг тухай бүр тооцоолох шаардлагатай бөгөөд энэ ч утгаараа хамгийн нарийн төвөгтэй тооцоолол болох даатгалын нөөц сангийн тооцооллыг өдөр бүр гаргах боломж даатгагчид бүрдсэн. Банкны тухай хуулийн дагуу банк санхүүгийн тайлангаа 1 дүгээр сард багтаан Монгол банканд ирүүлдэг. Даатгал бол банкнаас илүү өдөр бүр эрсдэлээ тооцоолох шаардлагатай төдийгүй программ хангамжийн хувьд хангалттай туршлагыг хуримтлуулсан тул даатгалын компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланг 1 дүгээр сард багтаан авах боломжтой юм.
38.	38.2. Хороо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 33.1.1 болон 33.1.2-т заасан этгээдээс аудитын тайлан гаргаж өгөхийг 35.2-ийг үндэслэн хэдийд ч шаардаж болно.	Үгүй. Аудитын тухай хуулийн 11.1."Төрийн эрх бүхий хяналт зохицуулалтын байгууллага, банк санхүүгийн байгууллагын хүсэлтээр аж ахуйн нэгж, байгууллагаас завсрын санхүүгийн тайландаа энэ хуулийн 9.1.2, 9.1.3, 9.1.4-т заасан ажил үйлчилгээг хийлгэж болно." гэж заасан. Иймд даатгалын компанийн санхүүгийн чадавх, төлбөрийн чадвар болон шинэ бизнесийн үйл ажиллагаа зэрэгтэй уялдуулан Хороо аудитын тайланг хэдийд ч шаардаж болно.

<p>39.</p>	<p>39.1. Актуарын мэргэжлийн байгууллага актуарчаар ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг сонгон шалгаруулж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно"</p> <p>39.2. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох ажиллагааг актуарын мэргэжлийн байгууллагын дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>39.3. Актуарын мэргэжлийн байгууллага энэ хуулийн 39.1-д заасны дагуу эрх авсан актуарчийн нэрсийн жагсаалт, түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.</p>	<p>Үгүй. Ирүүлсэн саналын зүйл заалт зөрүүтэй байна.</p> <p>Хуулийн төслийн 20.2.2-т заасан Даатгалын мэргэжлийн холбоо ангилалд даатгалын актуарч нарыг нэгтгэсэн нийгэмлэг, холбоо орох боломжтой бөгөөд Хороо захиргааны гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох эрх, үүргээ шилжүүлэх боломжтой юм.</p>
<p>40.</p>	<p>39.4. Хасах саналтай байна. (Хууль зөрчих эрхгүй аудиторыг хууль зөрчсөнийг нь хариуцлагдажуулахгүй байхаар заасан нь хууль зөрчихийг дэмжсэн байна)</p>	<p>Хэсэгчлэн тусгах. Дараах байдлаар тусгав. "39.4.Аудитын байгууллага болон аудитын байгууллага байсан этгээд нь энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй"</p>
<p>41.</p>	<p>40.1. Даатгагч нь заавал актуарчтай байх бөгөөд актуарч нь энэ хуулийн 39.1-д заасны дагуу актуарын мэргэжлийн байгууллагаас эрх авсан этгээд байна.</p>	<p>Үгүй. Ирүүлсэн санал тодорхой бус, зүйл заалт зөрүүтэй байна.</p> <p>Хуулийн төслийн 20.2.2-т заасан Даатгалын мэргэжлийн холбоо ангилалд даатгалын актуарч нарыг нэгтгэсэн нийгэмлэг, холбоо орох боломжтой бөгөөд Хороо захиргааны гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох эрх, үүргээ шилжүүлэх боломжтой юм.</p>
<p>42.</p>	<p>41.1.Актуарч нь өөрийн үйл ажиллагаандаа даатгалын багц дүрэмд заасан актуарын стандарт болон актуарын мэргэжлийн байгууллагаас гаргасан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.</p>	<p>Үгүй. Ирүүлсэн санал тодорхой бус, зүйл заалт зөрүүтэй байна.</p> <p>Хуулийн төслийн 20.2.2-т заасан Даатгалын мэргэжлийн холбоо ангилалд даатгалын актуарч нарыг нэгтгэсэн нийгэмлэг, холбоо орох боломжтой бөгөөд төсөлд тусгасны дагаа мэргэжлийн холбоо нь гишүүдийн үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрмийг батлах юм.</p>

	43.1. Актуарчийн хамгийн гол эрх нь хараат бус байх бөгөөд аливаа тооцооллыг хэн нэгний нөлөө, шахалтад орохгүйгээр хийж гүйцэтгэх, баталгаажуулах бөгөөд хэрэв нөлөө, шахалт ирэх бол тооцооллыг баталгаажуулахаас татгалзах эрхтэй байх.	Тийм. Хуулийн төсөлд актуарчийн хараат бус байх зарчмыг эрх, үүргийн хамт тусгав.
43.	42.5. Актуарч нь даатгалын багц дүрэмд заасан агуулга, хэлбэрийн дагуу мэргэжлийн түвшинд хяналт шалгалтын тайлан бэлтгэнэ.	Тийм. Хуулийн төслийн 40-р зүйлд тусгав.
44.	44.4. Даатгагч актуарчтай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд актуарч нь Зохицуулах хороо болон актуарын мэргэжлийн байгууллагад дараах асуудлаар мэдээлэл өгнө:	Үгүй. Хуулийн төслийн 20.2.2-т заасан Даатгалын мэргэжлийн холбоо ангилалд даатгалын актуарч нарыг нэгтгэсэн нийгэмлэг, холбоог оролцуулах бөгөөд Хороо гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох эрх, үүргээ шилжүүлэх боломжтой юм.
45.	47.6. Актуарч болон актуарч байсан этгээд тайлан болон энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороо болон актуарын мэргэжлийн байгууллагыг хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.	Хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 20.2.2-т заасан Даатгалын мэргэжлийн холбоо ангилалд даатгалын актуарч нарыг нэгтгэсэн нийгэмлэг, холбоог оролцуулах бөгөөд Хороо гэрээ байгуулсны үндсэн дээр холбогдох эрх, үүргээ шилжүүлэх боломжтой юм.
46.	45.1. Даатгагч нь актуарчийг томилоогүй бол Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасан актуарын мэргэжлийн байгууллагаас баталгаажуулсан актуарын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг актуарчаар томилно.	Үгүй. Хуулийн төслийн 20.2.2-т заасан Даатгалын мэргэжлийн холбоо ангилалд даатгалын актуарч нарыг нэгтгэсэн нийгэмлэг, холбоог оролцуулах бөгөөд Хороо захиргааны гэрээгээр холбогдох эрх, үүргээ шилжүүлэх боломжтой юм.
47.	45.2.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу томилогдсон актуарч нь даатгагчийн актуарчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.	Үгүй. Санал тодорхой бус.
48.	49.1.1 Хасах саналтай байна.Үндэслэл: 1.Чадавх, нөөц сангийн хүрэлцээ хүрэх эсэхээс үл хамааран дотоодын даатгагчид 10% хэмжээг заавал даатгах нь эрсдэлтэй. 2. Эсхүл төрийн өмчийн даатгалуудыг retention хийхийг үүрэг болгож болно. Бүх давхар даатгалын эрсдэлийг заавал дотоодын даатгагчид даатгуулах боломж зарим бүтээгдэхүүний хувьд боломжгүй.	Хэсэгчлэн тусгав. Даатгалын компаниуд 2019-2023 оны хооронд хураамжийн нийт орлогын 34.0 хувийг буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна. Олон улсын туршлагыг судалж үзвэл:

		<p>ОХУ-ын хуульд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг заавал даатгуулдаг. Беларусь улс Belarus Re төрийн өмчит давхар даатгалын компанийг 2006 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2006 онд 10 хувь, 2007 онд 20 хувийг шилжүүлдэг болгож, хуульд нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байгаа. Хуульд зааж өгсний үр дүнд бүх давхар даатгалын гэрээ тус байгууллагаар дамждаг болж хяналт хийгдсэний дагуу Үндэсний давхар даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгож чадсан байна.</p> <p>Энэтхэгийн ердийн даатгалын компаниуд давхар даатгалынхаа 10 хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулдаг байсан зохицуулалтыг өөрчилж, 5 хувийг заавал шилжүүлэх зохицуулалттай. Эндээс харахад ихэнх улсууд давхар даатгалын зах зээлийг эхлээд төрийн дэмжлэгтэйгээр өргөжүүлэн, үүнийхээ дараа алхам алхмаар оролцоогоо бууруулдаг байна. Иймд нэг талаасаа дотоодын давхар даатгалын тогтолцоог сайжруулах, нөгөө талаас гадагшаа урсах мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах зорилгоор дотоодын давхар даатгалд даатгуулах хувийг хуульд тусгаж өгөх нь зүйтэй байна.</p>
49.	51.2. Хасах саналтай байна. Аливаа орлогоос нөөц сан байгуулдаг үндсэн мөн чанар байна. Давхар нөөц сан байгуулахаар ойлгогдож байна.	Үгүй. Төслийн 28.1-д даатгалын нөөц санг байгуулах талаар зохицуулалтыг тусгасан хэдий ч хамтын даатгалын хувьд хүлээн авсан эрсдэлийн хэмжээгээр оролцсон даатгагч бүр нөөц санг байгуулах талаарх зохицуулалт орох нь зүйтэй юм.
50.	53.3. Хасах саналтай байна.	Үгүй. Энэхүү заалт нь төслийн 19.1-заалттай уялдаж байгаа тул хасах боломжгүй. Уг

		заалтыг хасах шаардлага, үндэслэлийг ирүүлсэн тохиолдолд судлах боломжтой.
51.	59 дүгээр зүйл: Даатгуулагч тэргүүн ээлжид өөрөө хохирол үнэлгээчнээ томилж зардлаа хариуцна. Хэрэв даатгагч уг үнэлгээ нь үндэслэлгүй буюу хэт өндөр тогтоогдсон гэж үзвэл өөрийн зардлаар хохирол үнэлгээчин томилж болно. Талууд санал зөрчвөл зардлаа хувааж хөндлөнгийн үнэлгээчин томилох бөгөөд энэ нь эцсийн үнэлгээ байна.	Үгүй. Олон улсын практикт даатгалын хохирол үнэлэгчийг даатгагчийг төлөөлөх хохирол үнэлэгч буюу loss adjuster, даатгуулагчийг төлөөлөх хохирол үнэлэгч буюу public adjuster, мөн хараат бус хохирол үнэлэгч буюу independent loss adjuster гэж ангилдаг. Үүний дагуу хохирол үнэлэгчийг 2 ялган даатгалын компанийн ажилтан буюу даатгагчийн томилсон хохирол үнэлэгчээр эхэлж даатгалын хохирлын үнэлгээг хийж, даатгуулагч зөвшөөрвөл нөхөн төлбөрийг олгохоор зохицуулсан бөгөөд энэхүү үнэлгээг даатгуулагч зөвшөөрөхгүй бол хөндлөнгийн буюу хараат бус хохирол үнэлэгчээр үнэлгээг хийлгэнэ. Ингэснээр даатгалын хохирлын үнэлгээ хурдан шуурхай хийгдэх, даатгуулагчид даатгалын хохирлын үнэлгээний зардлын ачаалал буурах болон даатгалын салбарын нэр хүнд өсөх боломж бүрдэх юм. Мөн нөгөөтэйгүүр хөндлөнгийн даатгалын хохирол үнэлэгч илүү мэргэших боломж бүрдэнэ.
52.	61 дүгээр бүлэг. Хасах саналтай байна. Зарчмын хувьд буруу зорилго, томьёолол байна гэж үзэж байна. Үндэслэл: Цахим даатгал гэдэг нь даатгалын гэрээг хүргэх аргачлал болохоос тусгайлсан зохицуулалт шаардлагагүй. Даатгуулагч нэр томьёонд багтсан этгээдэд үйлчилгээ хэрхэн хүрч байгаагаас тухайн даатгагчийг сонгох асуудал байгаа болохоос энэ аргачлалыг зохицуулах, мөн тусгай зөвшөөрөл олгох гэдэг нь Аж ахуйн нэгжийн зөвшөөрлийн хуулиас хэтэрсэн эрхийг Хороо эдлэх, хүртээмжийг хязгаарлахаар байна. Энэ хэсгийг хуульчлахаас илүүтэй зөвлөмжийг өгч ажиллах нь зөвхөн Хорооны бус мэргэжлийн байгууллагын ажил байна.	Хэсэгчлэн тусгав. Энэхүү зохицуулалт нь даатгагчийн цахим хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх буюу даатгалын гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалт биш бөгөөд даатгалын салбарт шинэ техник, технологи нэвтрүүлэхтэй холбоотой зохицуулалт тул шаардлагатай өөрчлөлтийг тусгав.
53.	63.1. Даатгагч нь даатгалын зуучлагч, төлөөлөгчөөс бусад этгээдэд даатгалын борлуулалтын урамшуулал, орлогын шимтгэл зэрэг аливаа хэлбэрийн шан харамж, хөлс олгохыг хориглоно.	Хэсэгчлэн тусгав. Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "даатгалын зуучлагч" гэж даатгалын брокер, даатгалын төлөөлөгчийг хамаарахаар тусгасан

		байгаа тул төслийн 63.1-д "даатгалын төлөөлөгч" гэж нэмж тусгах шаардлагагүй юм.
54.	65.3. Даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөл нь даатгагчийн зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, аудит, хөрөнгө оруулалтын бодлого, журмыг батлан мөрдүүлж болно.	Хэсэгчлэн тусгав. Даатгагч нар нь Хорооноос баталсан Компанийн засаглалынн кодекссыг заавал мөрдөх шаардлагатай тул саналыг дараах байдлаар тусгав. "Даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, дотоод аудит, комплайнсын хяналт, андеррайтинг, нөхөн төлбөр, харилцагчийн гомдол шийдвэрлэх, хөрөнгө оруулалт болон шаардлагатай гэж үзсэн бодлогын баримт бичиг, журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина."
55.	67.3.2. даатгагчийн төлбөрийн чадвар	Үгүй. Даатгагчийн ашигт ажиллагааны талаар нийгэмд буруу ойлголт ихээр бий болоод байна. Иймд компанийн нөхөн төлбөр олголт болон хосолсон харьцааны талаарх мэдээллийг ил тод байршуулах нь нэгд, нийгэм дэх буруу ойлголтыг залруулах, хоёрт даатгуулагч нарт даатгагчийн үйл ажиллагааны гол үзүүлэлтийн хувьд харьцуулалт хийх боломжийг олгох нь зүйтэй.
56.	68.1. Хасах саналтай байна. Мэргэжлийн холбоодын хэрэгжүүлэх чиг үүрэг болно.	Үгүй. IAIS байгууллагаас гаргасан Даатгалын тулгуур зарчим 19 "Зах зээлийн зохистой үйл ажиллагаа"-нд "Зохицуулагч байгууллага нь даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамтран ажиллах үедээ болон гэрээний өмнө болон хойно нь хэрэглэгчдэд зохистой хандах, гэрээнд тусгасан үйлчилгээгээ бүрэн үзүүлэх шаардлагыг тогтооно." гэж заасны дагуу зөвхөн зах зээлийн ёс зүйгээс гадна зохистой үйл ажиллагаанд хамааралтай даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах гээд бусад зөвлөмж, шаардлагыг тавих нь зүйтэй.

57.	68.2. Хасах саналтай байна. Хамтын ажиллагаатай байгууллагууд, харилцагчиддаа харилцагчийн бэлэг өгөхийг ч хориглосон байна. Энэ хэсгийн холбооны ёс зүйн кодекст оруулж мөрдүүлж болно.	Үгүй. Энэхүү заалт ДОШ нэрээр даатгуулагч нарт аливаа мөнгөн урамшуулал олгож байгаа асуудлыг зохицуулах зорилготой бөгөөд даатгалын компанийн маркетинг, зар сурталчилгааны асуудалд оролцох заалт биш юм.
58.	70 дугаар зүйл. Хасах саналтай байна. 20.6 дугаар заалттай холбоотой Мэргэжлийн холбоо аливаа мэдээллийн санг байгуулж, төвлөрүүлэх болон холбогдох аргачлалыг хэрэгжүүлнэ.	Хэсэгчлэн тусгав. Мэргэжлийн холбоо нь аливаа мэдээллийн санг байгуулж, ашиглах нь нээлттэй юм. Энэ нь салбарын хэмжээний мэдээллийн сангийн асуудал бөгөөд мэдээллийг төвлөрүүлэх, түүнийг нууцлалыг хангах асуудалтай холбоотойгоор холбогдох зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй.
59.	72.1.6 Хасах саналтай байна.	Хэсэгчлэн тусгав. Дараах байдлаар тусгав. Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой "шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс гаргуулан Хороонд өгөх;"
60.	76 дугаар зүйл. Хасах саналтай байна. Шаардлагагүй.	Үгүй. Энэ нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа заалт бөгөөд даатгалын тулгуур зарчим "ICP 3. Мэдээлэл солилцоо, нууцлалд тавигддаг шаардлага. Зохицуулагч байгууллага нь бусад зохицуулагч болон эрх бүхий байгууллагатай мэдээллийн нууцлалын байдал, зорилго, хэрэглээнд тавих шаардлагын хүрээнд мэдээлэл солилцож ажилладаг байх" шаардлагыг тусгасан байдаг.
61.	77.1.12 Хасах саналтай байна. Давхар даатгалын төлөвлөгөөг Хороогоор батлуулах зарчмыг дэмжихгүй байна.	Үгүй. ДТХ-н 47 дугаар зүйлийн дагуу даатгагч давхар даатгалын төлөвлөгөөг батлуулах заалтыг хуулийн төслөөс хасаж, даатгагч нар давхар даатгалын төлөвлөгөөг Хороонд мэдээлэл хүргүүлэх байдлаар ирүүлэхээр өөрчилсөн. Иймд Хорооноос давхар даатгагчийн төлөвлөгөөг батлахгүй. Харин давхар даатгалын төлөвлөгөө, тайланд тавигдах шаардлагыг журмаар тогтоож өгөхөөр заасан.

62.	79.1.1. Түдгэлзүүлэх үндэслэлийг зөв тогтоож өгмөөр байна. ЗҮХ гэхээс илүүтэй төлбөрийн чадвар, нөөц сангийн байршуулалт, гэх мэт зөв төвлөрөл баймаар байна.	Үгүй. Санал тодорхой бус байна. Төлбөрийн чадвар, нөөц сангийн байршуулалтын асуудлыг 77.1-д тусгасан байна.
63.	79.2. Хасах саналтай. Үндэслэл: Түдгэлзүүлэх үндэслэл хамааралгүй буюу энэ мэт үйлдэл гардаггүй. Хороо тусгай зөвшөөрлийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.	Үгүй. Санал тодорхой бус байгаа тул хүлээж авах боломжгүй.
64.	79.3.Хороо тусгай зөвшөөрлийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.	Үгүй. Агуулгын хувьд ижил байна. Түдгэлзүүлэх үндэслэлээс хамаарч хугацааг тогтооно гэж ойлгоно.
65.	83.1.4. Хасах саналтай. Даатгагч бүр харилцан даатгуулагч гэх нэр томъёонд хамаарах харилцан адилгүй этгээдэд учрах эрсдэлийг удирдах учраас хураамжийн хувьд ижил байх боломжгүй бөгөөд нийгмийн болон байгаль орчны хувьд тохиолдох эрсдэлийн дундаж хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагын болон актуарчийн зөвлөмжийн дагуу боловсруулж даатгагч бүр харилцан адилгүй мөрдөнө.	Үгүй. Агуулгын хувьд ижил байна. Түдгэлзүүлэх үндэслэлээс хамаарч хугацааг тогтооно гэж ойлгоно.
66.	83.1.10. Хасах саналтай байна. Тодорхойгүй байна.	Үгүй. Хорооноос өгөх даалгавар бөгөөд тухайн даалгаварт үндэслэлийг бичих бөгөөд гүйцэтгэх арга нь хуульд заасан хүрээнд нээлттэй гэж ойлгож болно. Саналыг тусгах үндэслэлийг ирүүлээгүй.
67.	83.2. Хасах саналтай байна. Тодорхойгүй байна.	Үгүй. Тухайн даалгавартаа тодорхой дурдаж өгнө.
68.	84.3. Хасах саналтай байна.	Үгүй. Уг заалтыг хасах үндэслэл, шаардлага тодорхой бус байна.
69.	91.4. Омбудсмантай холбоотой зохицуулалтыг тусгах шаардлагатай. Омбудсманыг ямар этгээд томилох, зөрчил маргааныг хэрхэн шийдвэрлэх зохицуулалт огт тусгагдаагүй байна. Эсхүл омбудсмантай холбоотой холбогдох хууль батлагдах хүртэл хасах саналтай байна.	Хэсэгчлэн тусгав. Төсөлд шаардлагатай өөрчлөлтийг тусгасан.
VI.Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо		
1.	1.1 Энэ хуулийн зорилт нь даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, олон нийт, даатгуулагч болон хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. [Тайлбар: томоохон галын хэргүүдэд нийтийн эрх ашгийг хамгаалах шаардлага гардаг тул зохицуулалтыг нэмэх шаардлагатай]	Үгүй. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Хороо нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй хэмээн тодорхойлсон. Иймд энэхүү саналыг тусгах боломжгүй.

2.	4.1.19 олон нийтийн эрх ашигт хамааралтай даатгалын гэрээ гэдэгт худалдаа үйлчилгээний талбай түрээслүүлэгч, барилга, уул уурхай, хүнд үйлдвэр эрхлэгчээс даатгуулах гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, галын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал хамаарна. гэж нэмэх	Үгүй. Эдгээр нэрлэсэн даатгалууд нь даатгалын бүтээгдэхүүн бөгөөд Даатгалын тухай хуулиар даатгалын аливаа хэлбэр, бүтээгдэхүүнийг зохицуулах шаардлагагүй бөгөөд төслийн "6.4.Даатгалын хэлбэр тус бүр нь төрөлтэй байх бөгөөд сайн дурын даатгалын төрлийг Хороо тогтооно." гэж заасны дагуу Хорооноос журмаар тогтоох боломжтой.
3.	8 дугаар зүйл. Даатгалын хураамж 8.1.Хураамжийн хэмжээ нь даатгагчаас баталсан актуар тооцоололд үндэслэнэ. 8.2.Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг даатгагч тогтооно. гэж өөрчлөх	Үгүй. Төслийн 8.2-т туссан байна.
4.	9.5.Даатгагч гэрээнд заагаагүй болон даатгалын тохиолдолд хамааралгүй, хохирлыг нотлоход ач холбогдолгүй баримт бичгийг даатгуулагчаас шаардахыг хориглоно. гэж өөрчлөх	Тийм. Даатгагч хохирлыг нотлоход шаардлагагүй материалыг шаардаж, түүнд үндэслэн даатгалын нөхөн төлбөр олгохгүйгээр даатгуулагчийг хохироох, даатгалын нөхөн төлбөр олгох хугацааг удаашруулах зэрэг үйлдлүүд гардаг тул энэхүү заалтыг журамд тусгаж, хэрэгжилтийг хангах боломжтой.
5.	9.12 “Даатгагч нь даатгалын гэрээнд нөхөн төлбөр олгоход хамаарахгүй заалтад даатгах үйлчилгээний зорилгыг үгүйсгэх, даатгасан эрсдэлтэй зөрчилдөх заалт оруулахыг хориглоно.” гэж нэмэх	Үгүй. Даатгалын гэрээний ерөнхий харилцаа Иргэний хуулиар зохицуулагддаг. Үүнээс гадна энэ мэт асуудлыг даатгалын журмаар зохицуулах боломжтой тул саналыг одоогийн байдлаар тусгах боломжгүй.
6.	9.13 “Даатгагч нь даатгуулагч болон түүний ажилтан, гэрээнд дурдсан этгээдээс хохирлын нөхөн төлбөрийг доор дурдсанаас бусад тохиолдолд эргүүлэн нэхэмжлэхгүй.” гэж нэмэх 9.13.1 Даатгуулагч даатгалын мансууруулах бодис хэрэглэсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн, эрүүгийн гэмт хэрэгт оролцсон, үйлдсэнээс даатгалын тохиолдлыг бий болгосон;	Үгүй. Даатгалын гэрээний ерөнхий харилцаа Иргэний хуулиар зохицуулагддаг.Үүнээс гадна энэ мэт асуудлыг даатгалын журмаар зохицуулах боломжтой тул саналыг одоогийн байдлаар тусгах боломжгүй.
7.	9.11.Даатгалын тохиолдлын улмаас хөдлөх хөрөнгө бүрэн утсан, сүйрсэн, дахин сэргээгдэх боломжгүй болсон тохиолдолд учирсан хохирлыг даатгагч бүрэн барагдуулсан бол даатгуулагч нь уг хөдлөх хөрөнгийн үлдэгдлийг өмчлөх эрхээ	Үгүй. Газар болон түүний дээрх үл хөдлөх эд хөрөнгийн эрх тусдаа учир тийм асуудал үүсэхгүй.

	даатгагчид шилжүүлнэ. [Тайлбар: Үл хөдлөх хөрөнгөд газрын өмчлөх эрх багтдаг тул өмчлөх эрх шилжүүлдэггүй.]	
8.	10.2.11.даатгалын брокер, даатгалын төлөөлөгчид борлуулалтын орлогын шимтгэлийг актуар тооцоололд дурдсан хязгаараас хэтрүүлж олгохгүй байх; энэ заалттай холбоотой хариуцлагыг нэмж оруулах	Үгүй. Сайн дурын даатгалын хураамжийн тооцооллыг даатгагч өөрөө актуар тооцоололд үндэслэн гаргана. Энэхүү бизнесийн үйл ажиллагаанд Хороо оролцож холбогдох шаардлагыг тавих боломжгүй бөгөөд тийм учраас хуулийн төсөлд зөвхөн тусгай зөвшөөрөлгүй этгээдэд борлуулалтын орлогын шитгэл олгохыг хориглосон зохицуулалтыг тусгасан.
9.	10.2.12 Даатгалын тохиолдол болоход даатгуулагчид хохирлыг бууруулах болон даатгалын нөхөн төлбөрт бүрдүүлэх акт баримт бичгийг тодорхой заасан зааварчилгааг цахим болон бичгээр өгөх; гэж нэмэх	Тийм. Хуулийн төслийн 10.2.3 болон 10.2.5 дахь заалтуудыг өөрчлөн найруулах байдлаар саналыг тусгах боломжтой байна.
10.	10.2.13 Даатгалын гэрээнд даатгалын тохиолдлыг хэрхэн тодорхойлох, баталгаажуулах талаар тодорхой заах; гэж нэмэх	Үгүй. Даатгалын гэрээний ерөнхий харилцаа Иргэний хуулиар зохицуулагддаг. Үүнээс гадна энэ мэт асуудлыг даатгалын журмаар зохицуулах боломжтой тул саналыг одоогийн байдлаар тусгах боломжгүй.
11.	19.2.Гадаадын даатгагчтай ердийн болон давхар даатгалын гэрээ байгуулах даатгагчид дараах тохиолдолд энэ хуулийн 19.1 дэх хэсэг хамаарахгүй:	Үгүй. Ердийн даатгалын хувьд хуулийн төсөлд заасны дагуу зөвхөн тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулахаар тусгасан байгаа.
12.	19.2.3. Даатгуулагчаас шаардсан даатгалын үйлчилгээний хязгаар үнэлгээ дотоодын даатгагчийн үйлчилгээнээс хэтэрсэн, тухайн үйлчилгээнд тавьсан шаардлага, нөхцөл даатгуулагчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байхгүй байх тохиолдолд; /Байгаль орчны эрсдэл, ковидын өндөр хамгаалалттай даатгал, цахим халдлагын даатгал, өмчлөх эрхийн даатгал гэх мэт манай улсад байхгүй даатгалын үйлчилгээг гаднын даатгагчаас авч болохоор зохицуулах /	Тийм. Даатгагчийн дааж чадахгүй болон зах зээл дээр бэлэн байхгүй, боловсруулах боломжгүй онцгой төрлийн даатгалын бүтээгдэхүүний хувьд төслийн 19.1 дэх заалт хэрэгжихгүй байх боломжтой тул энэхүү заалтыг 19.2-т нэмж оруулах саналыг дэмжиж байна.
13.	19.1 Даатгуулагч нь олон нийтийн эрх ашигт хамааралтай даатгалын гэрээ байгуулахдаа заавал СЗХ-ны тусгай зөвшөөрөл бүхий даатгалын брокероор дамжуулан байгуулах бөгөөд уг гэрээг СЗХ-нд бүртгүүлнэ.	Үгүй. Зах зээлд оролцогчдын бүгдийн оролцоог эрх тэгш хангасан зохицуулалт байх шаардлагатай байтал нэг талд давуу эрх олгосон зохицуулалт оруулах боломжгүй.

	[Тайлбар: Нийтийн худалдааны талбай, уул уурхай, барилга, хүнд үйлдвэр зэрэг олон нийтийн эрх ашгийг хөндсөн даатгалыг бүртгэх хяналт тавих шаардлагатай тул нэмэлтээр оруулах саналтай. энэ заалттай холбоотой хариуцлагыг нэмж оруулах.]	Даатгалын зуучлагчийг сонгох эсэх асуудал нь даатгуулагчийн эрхийн асуудал юм.
14.	20.2.3. Даатгалын зуучлагчдын мэргэжлийн холбоо гэж нэмэх	Үгүй. ДТХ-ын шинэчилсэн найруулгын төслийн 20.2.2-т заасны дагуу даатгалын зуучлагч эсхүл брокерууд нэгдэн Даатгалын мэргэжлийн холбоог байгуулах боломжтой. Тус хуулийн төслөөр даатгалын мэргэжлийн холбооны эрх, үүрэг, шаардлагыг тодорхой зааж өгсөн байгаа.
VII. Сангийн яамны сайтаар олон нийтийн хэлэлцүүлэгт ирсэн саналууд		
1.	Ц.Будмаа: 4.1.9 Даатгалын тохиолдлын найруулгыг дараах байдлаар засах саналтай "Даатгалын зүйлд даатгалын гэрээгээр тохиролцсон нөхцөл орчин бүрдэж, хохирол учрахыг"	Тийм. Даатгалын тохиолдлыг даатгалын гэрээтэй холбохыг дэмжих боломжтой..
	Ц.Будмаа: 4.1.12 Даатгалын мэргэжлийн оролцогч дотор даатгагч орсон байтал андеррайтер буюу даатгагчийн ажилтныг давхар оруулсан байна. Андеррайтер бол банкаар бол зээлийн эдийн засагчтай адилтгаж болох ажил мэргэжил юм. Актуарчийг мөн оруулсан ба энэ нь хорооноос эрх авдаг гэсэн утгаараа мэргэжлийн оролцогч байх нь зөв бизээ. Андеррайтеруудад хорооноос эрх өгөхгүй тохиолдолд энд тусгайлан оруулж өгөх нь оновчгүй.	Тийм. Даатгалын андеррайтер нь даатгалын компанийн ажилтан бөгөөд нэмэлт зөвшөөрөл, эрх шаарддаггүй тул даатгагчийн ажилтан гэдгээрээ даатгалын мэргэжлийн оролцогчид ордог тул тусгайлан оруулахгүйгээр хасах, саналыг тусгах
	Ц.Будмаа: 4.1.15 дах "Толгой даатгагч" тодорхойлолтыг хийхдээ Монгол улсад хамтын даатгалын зарчмыг олон улсад явагддаг нийтлэг ойлголтын дагуу хөгжүүлэхийн тулд зөв тодорхойлох шаардлагатай. Толгой даатгагч буюу leader нь тухайн даатгалын төрлөөр зах зээл дээр өөрийн гэсэн туршлагатай бөгөөд үнэ ба нөхцөлийг тогтоох хамгийн сайн боломжтой (чадавхтай) компаниудыг хэлдэг. Брокерын зүгээс нэг даатгагч дангаараа хариуцаж үл чадах аливаа эрсдэлийг олон даатгагчид хувааж гэрээг байгуулахын тулд хамгийн сайн туршлагатай компаниар эхэлж үнэ ба нөхцөлийг тогтоолгон, бусад компаниуд тухайн туршлагатай компанийг дагаж гэрээнд тодорхой хувь хэмжээгээр оролцдог. Үнэ ба нөхцөлийг тогтоох, нөхөн төлбөрийн шийдвэрийг гаргах зэрэг тэргүүлж оролцдог тул leader буюу толгой даатгагч гэдэг. Хамтын даатгалын сонгодог практик нь брокер өөрийн харилцагчийн эрсдэлийг олон даатгагч дунд хувааж байршуулах практик байдаг. Даатгагч бүр өөрийн дааж чадах хэмжээгээр оролцдог тул толгой даатгагч 100% авч чадахгүй тохиолдолд хамтын даатгалын санаачилгыг гаргадаг этгээд нь толгой даатгагч бус	Тийм. Даатгалын зуучлалын тухай хуульд даатгалын зуучлагчийг хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцох боломжийг олгосон хэдий ч зөвхөн толгой даатгагч даатгалыг зохион байгуулахаар орсон байгааг засах, мөн хамтын даатгалын үйл ажиллагаанд толгой даатгагчийг хамтын даатгалыг зохион байгуулах ёстой хэмээн үүрэг өгөх нь зохимжгүй байна.

	<p>брокер байдаг. Иймд хуулийн тодорхойлолтыг дараах байдлаар өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. "Толгой даатгагч" гэж аливаа эрсдэлийг даатгах нөхцөл, болзол, хураамжийг тогтоон тухайн эрсдэлд тодорхой хувь хэмжээгээр оролцох ба тухайн даатгалын гэрээнд оролцсон бусад даатгагчдыг төлөөлөн даатгалын брокер эсвэл харилцагчтай (даатгалын брокергүй тохиолдолд) хэлцэл хийх, даатгалын гэрээнд өөрчлөлт хийх, даатгалын тохиолдол учирсан үед нөхөн төлбөрийн шийдвэрийг гаргах эрхтэй даатгагчийг. Уг тодорхойлолтод хамтран даатгах тухай саналыг хэн тавих талаар дурдахгүй байх нь зөв болно.</p>	
<p>2.</p>	<p>Ц.Будмаа: 9.7 Даатгалын компаниуд андеррайтинг хийхэд шаардлагатай мэдээллийг хүлээж авч чадахгүй байх, даатгуулагч гаргаж өгч буй мэдээллийнхээ бүрэн бүтэн, зөв найдвартай байдалд хайхрамжгүй хандаж байгаа зэргээс үүдэн даатгалын салбарын үнэ тогтоолт, эрсдэлийн удирдлага сайжрахгүй байна. Даатгалын компанийн хамгийн гол хэрэглэдэг түүхий эд болох мэдээллийн эрүүл аюулгүй байдал ихээр зөрчигдөж байгаа энэ үед даатгалын гэрээ байгуулахаар хэлцэл хийж байх үед гаргаж өгөх мэдээллийн алдаатай, худал, бүрэн бус байдлаас үүдэн нөхөн төлбөрийг олгохгүй байх зохицуулалт байх нь шаардлагатай. Их Британийн Marine Insurance Act 1906, сүүлд батлагдсан Insurance Act 2015-аар даатгалын салбарын тогтвортой байдлыг хангахын тулд ямар мэдээллийг өгөх ёстой, ямар байдлаар, хэзээ өгөх ёстой зэргийг маш тодорхой хуульчилж, тэдгээрийн зөрчлийн үр дагаврыг хуульд тодорхой оруулсан байна. Даатгуулагчаас дата мэдээллээ бүрэн, чанартай авч чадаагүй цагт хураамж тогтоолт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт зохих ёсоор явах боломжгүй. Даатгалын салбар чанартай мэдээлэл хэрэглэн тогтвортой найдвартай хөгжих боломжоос эдийн засгийн бусад секторуудын хөгжлийн хурд хамаарна</p>	<p>Хэсэгчлэн тусгав. "11.2.3.даатгалын гэрээ байгуулах болон даатгалын нөхөн төлбөртэй холбогдсон баримт материал, мэдээллийг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;" гэх заалт орсон.</p>
<p>3.</p>	<p>Ц.Будмаа: 49.2 заалтад дотоодын давхар даатгалын компанид 10-с доошгүй хувийг давхар даатгуулахаар заасан байна. Үндэсний компанийг чадавхжуулах, дотоодод хураамжийн боломжтой хэсгийг үлдээх санаачилга зөв хэдий ч, эрсдэлийн хувьд хязгаарлах, зохицуулалтын хувьд аажим явах шаардлагатай. Жишээлбэл, МИАТ компанийн агаарын хөлгийн даатгалын гэрээний 10% гэдэг бол Үндэсний давхар даатгалын компанийн хариуцаж дийлэхгүй хэмжээ юм. Иймд, зөвхөн хувь зааж өгснөөр дотоодын давхар даатгагчийг дэмжих санаачилга нь санхүүгийн хүндрэл рүү оруулж болзошгүй тул энд зайлшгүй тохируулга шаардлагатай. Үндэсний давхар даатгал компанийн өөрийн нэг эрсдэлээр хүлээх техник тооцооллын хязгаарыг харгалздаг байх зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжийн (Үндэсний давхар даатгал) өөрийн эрсдэл хүлээх чадварыг бодолцолгүйгээр хуульд хатуу зааж өгөх нь салбарт хүндрэл үүсгэх аюултай байна. Нөгөө талаас, ийм</p>	<p>Тийм. Даатгалын компаниуд 2019-2023 оны хооронд хураамжийн нийт орлогын 34.0 хувийг буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна.</p> <p>Олон улсын туршлага: ОХУ-ын хуульд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг заавал даатгуулдаг. Нэг даатгалын тохиолдолд 80 хүртэл сая ам.долларын эрсдэлийг хариуцна.</p>

